

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-45
1. Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэх	7-24
2. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	25-40
3. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	40-43
4. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	43-44
5. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Үргэлжлэл/	44-45

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 15-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Ганхүлэг, У.Отгонбаяр;

Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, З.Мэндсайхан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Н.Наранбаатар нар үг хэлэв.

Нэг.Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, Н.Наранбаатар, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Ц.Мөнхбат, П.Батчимэг, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, С.Замира, Б.Жаргалан, П.Батчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, А.Ундраа, Г.Ганбаатар, Б.Найдалаа, Б.Жаргалан, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:01/

Гурав.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Д.Батмөнх, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын зөвлөх М.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ж.Батжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 75.0 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.*“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын С.Лүндэг үг хэлэв.

Ж.Батжаргал: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

53.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 13 цаг 17 минутаас 13 цаг 43 минутад завсарлав.

Хуралдаан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Ж.Батжаргал: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Батжаргал: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 30 минут үргэлжилж, 24 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 54 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд Очирбатын Амгаланбаатар, Жигжидийн Батжаргал, Гомбын Ганбаатар, Замира, Идэрбат, Лүндэг, Мөнхбаясгалан, Найдалаа, Наранбаатар, Сэддорж, Ундраа, Уянга, Чинбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирж, хуралдааны ирц 54,2 хувьтай байх тул өнөөдрийн хуралдааныг эхлүүлье.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцүүлэхээр бэлтгэлийг ханган оруулж ирсэн байна.

Хэлэлцэх асуудал 1.Байнгын хорооны 2024 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан.

2.Ажлын хэсгийн тайлан тавьсантай холбогдуулж “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

3.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

4.Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай”

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу. Гомбын Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд. Энэ хэлэлцэх асуудал дээр нэмэлтээр асуудал орох боломж бий юу. Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалал дээр өнгөрсөн 7 хоногийн Байнгын хорооны хурал хуралдаж байх үед говийн бүсээс сонгогдсон бидний хэдэн гишүүд тойрогт ажиллаж байгаад, өнгөрсөн 7 хоногийн хуралд оролцож чадсангүй. Ялангуяа малчдын ноолууртай холбоотой, хөдөөгийн амьдралтай ер нь манай Хөдөө аж ахуйн байнгын хорооны гарч байгаа шийдвэрүүд, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрүүд хөдөө орон нутагт амьдрал дээр ерөөсөө хэрэгжиж байгаа юм алга. Түүнтэй холбоотой өнөөдөр ярилцах боломж бий юу.

Ж.Батжаргал: Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө юманд орж бэлтгэл хангагдаагүй юм байна. Тэгэхдээ эртээдийн Байнгын хорооны хурлаар Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээллийг нь сонсоод, тов

тодорхой чиглэл өгөгдсөн. Дан дамаа энэ ноолуурын борлуулалтын асуудал дээр үүссэн нөхцөл байдлыг судалж, шийдвэрлэх чиглэлээр тов тодорхой Засгийн газарт чиглэл өгсөн Байнгын хорооны тогтоол батлагдсан. Энэ дагуу Улсын Их Хурлын удирдлагууд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк бас тодорхой уулзалтууд зохион байгуулж, энэ чиглэл дээр дотоодын эх үүсвэрээ нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулаад ажиллаж байгаа. Өчигдөр би хангайн бүсийн зөвлөлийн хурал, Засгийн газрын хуралдааны мэдээллийг харж байсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд тодорхой байр суурь, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийсэн. Тийм учраас Улсын Их Хурал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо энэ улс орныхоо хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн ажил асуудлууд руу анхаарлаа хандуулж, тодорхой үүрэг чиглэлийг холбогдох байгууллагуудад өгсөн. Гагцхүү тэр шийдвэрийн хэрэгжилт хэрхэн зохион байгуулагдаж байна вэ, ямар үр дүн бий болж байна гэдэг талаас нь сонсох ёстой. Ийм л юм байна. Тогтоолоор бол тов тодорхой үүрэг чиглэлүүд нь өгөгдсөн. Энэ өөрөө технологийн цаг хугацаатай зүйл учраас энэ явц юман дээр нь тодорхой мэдээллийг нь сонсох бололцоо боломжууд байгаа. Та наад санал юмнуудаа албан ёсоор Байнгын хороондоо хандчих. Байнгын хороо ирэх 7 хоногийнхоо хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлаа зөвлөл юман дээрээ яриад шийдэх байх гэж би ингэж ойлгож байна. Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Энэ эхний асуудал утааны асуудлаарх ерөнхий сонсголын тайлангийн материалыг миний хувьд бол сая л авлаа. Бусад гишүүд хэзээ авсан юм бол. Танилцах хугацаа байсангүй. Дараагийн Байнгын хорооны хурлаар сонсох хүртэл хойшлуулах саналтай байна.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийн дундын групп дээр тов тодорхой тавигдчихсан байсан. Та тэндээс материалаа татаж уншиж, бэлтгэлээ ханга. Тийм учраас хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга уу. Тэгвэл хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг баталъя. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны 2024 оны 7 дугаар тогтоолоор байгуулагдсан Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан.

Ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн тайлан мэдээллээ хийе. Чинбүрэн гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ өглөөний амар амгаланг эрье. Мэдээж хяналтын сонсгол маань 4 дэд хэлэлцүүлэгтэй, 2 өдрийн сонсгол болсон учраас тайлан маань жаахан урт. Та бүхэн битгий их чилээрхээрэй. Тэгээд би аль болохоор товчилж хэлэхийг бас бодно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Улсын Их Хурлын хууль тогтоох хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдөл, цаашид нийтийн хүртэл цахим системийг хүлээн авсан. Ингээд цахим системээр хүлээн авахад 71.452 иргэн гарын үсэг зурснаар нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэх энэ хууль, эрх зүйн орчин бүрдсэн.

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн миний бие ахлуулж, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар, Хүний эрхийн дэд хорооны дарга Сүхбаатарын Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Цэндийн Баатархүү, Пүрэвийн Батчимэг, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Амгаланбаатарын Ганбаатар, Гомбын Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Сонгобайн Замира, Жаргалсайханы Золжаргал, Сүрэнжавын Лүндэг, Мэндбаярын Мандухай, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Загджавын Мэндсайхан, Бадрахын Найдалаа, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Отгоны Саранчулуун гэсэн нийтдээ 21 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Түүнчлэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 дугаар тогтоолоор Агаарын бохирдол, утааны асуудлаар зохион байгуулах ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар миний биеийг томилсон. Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудал, бодлого шийдвэр, хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдвээр зохион байгуулахаар тогтож, тус Байнгын хорооны 10 дугаар тогтоолоор баталсан.

Ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажлын хүрээнд дараах 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 194 иргэн, төрийн байгууллагын 93 албан тушаалтан оролцож, 75 иргэдийн төлөөлөл холбогдох төрийн байгууллагаас асуулт асууж, хариулт авч, 28 иргэн танилцуулга хийсэн байна. Үүнд:

2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Агаарын бохирдол, хүн амын эрүүл мэнд, амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх сэдвээр эхний хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Эрдэнэболд удирдан явууллаа. Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг нь шууд товч авч үзвэл 2023 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Б/2589 дүгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан Сайжруулсан хатуу түлш техникийн шаардлага, MNS56792022 стандартыг яаралтай шинэчлэх, Агаарын чанарын бүс рүү зөвшөөрөлгүй түүхий нүүрс оруулж байгаа эсэх, бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс болон бусад зүйлс түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж хэрэгжилтийг 7 хоног бүр тайлагнаж, шийдвэр гарч байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, 2010 оноос хойш агаар болон орчны бохирдолд анхаарал хандуулж эхэлснээс хойш олон хөтөлбөр төслийг хэрэгжүүлсэн хэдий ч эдгээр төсөл хөтөлбөрийн хамрах хүрээ хэт өргөн тусгагдсан. Өртөг зардал өндөр, бодит үр дүнд хүрэх санхүүжилт, институцүүдийн чадавх, салбар хоорондын уялдаа муу, хяналт, хариуцлагын эргэх холбоо сул байсан.

Цаашид бодлогын уялдаа зохион байгуулахыг сайжруулах хүрээнд холбогдох нарийн мэргэжлийн судал судлаач эмч нарыг төлөөллийн оролцоог хангасан төр, бизнес, хувийн хэвшил, иргэд, судлаачдын багийг байгуулж ажиллах, Байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа 30 орчим хууль, 200 орчим эрх зүйн акт, норм ба

дүрэм стандартын давхардал, зөрчил, хийдэл ихтэй байсан. Засгийн газраас 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн цаг хугацааны мөчлөгтэй, оновчтой, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, ач холбогдолтой шалгуураар үнэлэх шаардлагатай. Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ Улаанбаатар хотын гадаад, дотоод орчны агаар дахь ПМ10, ПМ2,5-ын агууламжийг бууруулсан боловч хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх хэмжээнд байсаар байна.

Түүхий нүүрсний хэрэглээний үед өвлийн улирлын агаарын чанарын найрлага дахь ПМ10, ПМ2,5 CO2 хэмжээ нэмэгдэхэд ураг аяндаа зулбалтын давтамж нэмэгдэж, үр хөврөл бүрэлдэх байдал буурах хандлага ажиглагдсан байна.

Монгол улсад агаарын бохирдлын эрсдэлт хүчин зүйлийн нөлөөгөөр уушгины хавдраар гадна элэгний хавдарт нөлөөлж, хавдрын өвчлөл жилээс жилд тогтвортой нэмэгдэж байна. Олон улсад хийгдсэн судалгаагаар түүхий нүүрсний хэрэглээний улмаас уушгины хавдар өвчний тохиолдлыг нэмэгдүүлж байгааг тогтоосон илтгэлүүдийг сонслоо.

2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр дараагийн 7 хоногт нь Утааны асуудал, стандарт, хяналт, зуух түлшний технологи сэдвээр 2 дахь хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан удирдан явууллаа.

Тус хэлэлцүүлэгт холбогдох төрийн зарим байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн, судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 120 гаруй хүн оролцсон. Эдгээрээс төрийн байгууллагын 27, бусад байгууллагаас 10, иргэн, хуулийн этгээдийн 62 төлөөлөл оролцлоо. Би энэ дээр зүгээр тодотгоод хэлэхэд бид бас энэ ерөнхий хяналтын сонсголын бас нэг сул тал бол яг 2 өдрийн хяналтын сонсгол дээр иргэн хуралд оролцохдоо асуулт асуух эрхгүй оролцдог. Тийм учраас бид энэ дэд хэлэлцүүлэг хийснээрээ иргэдийг асуулт асууж, төрийн ажил хариуцаж байгаа хүмүүсээс хариулт авах боломж олгосон нь бас энэ ерөнхий хяналтын сонсголыг нэлээн хэл ам, дуулианаас арай жоохон сул, бага болгож өгч чадсан гэдгийг бас энд нэмээд хэлчихье.

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг товч хэлье. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкагаас гаргасан 2022 оны тайланд гэр хорооллын 198.840 яндангаас гарч буй утаа агаарын бохирдлын 55,6 хувь, 804.656 автомашины утаа 28,9 хувийг, ДЦС-ын үнсэн сан зэрэг бусад үүсгүүр 15,5 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотын төвийн дүүргийн гэр хорооллын өрхийн тоо 2000 оноос 2022 он хүртэл 2,4 дахин нэмэгдсэн нь агаарын бохирдол нэмэгдэх үндсэн шалтгаан болсон.

Цаг уурын орчны шинжилгээний газрын 2023 онд хийсэн Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын бохирдлын эх үүсвэрийн судалгааны дүнгээр гэр хорооллын болон усан халаалтын зуух 80 хувь, авто тээврийн хэрэгсэл 10 хувь, ДЦС 6 хувь, хог, шороо, хөрсний бохирдол 4 хувьтай байна. Мидлинг болон хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлшний техникийн үзүүлэлтүүдийг харьцуулахад дэгдэмхий 51,9, хүхэр 57,7, үнслэг 37,2 хувиар бага байгаа нь хагас коксжсон сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр агаарын чанар сайжруулахаас шууд нөлөө үзүүлэх нь туршилтаар тодорхойлогдсон. Түлшний

горим алдагдаж дутуу шаталтын явцад угаарын хий, дэгдэмхий органик нэгдлүүд үүсэх эрсдэл гардаг. Сайжруулсан шахмал түлш хэрэглэснээр түүхий нүүрсний хэрэглээг 60 хувиар бууруулж, илчлэгийг нэмэгдүүлж, хэрэглээг 54 хувиар бууруулснаар энэ хэмжээгээр агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан гэж үзэх боломжтой.

Чийг болон дэгдэмхий хийн үзүүлэлтийг бууруулсан сайн талтай ч үнслэг болон хүхрийн хэмжээ нэмэгдсэн сөрөг үр дүн гарсан. Гэвч үүнийг нийт хэрэглэж байгаа түлшний хэмжээнд авч үзвэл түлшнээс ялгарч болох хүхрийн хэмжээ 3 хувиар, үнслэгийн хэмжээ 19 хувиар тус тус бууруулсан гэсэн дүгнэлт гарсан байна.

Цаашид түүхий эд бүтээгдэхүүний стандартыг сайжруулах замаар түлшний чанарыг дээшлүүлэх, яндангийн тоо, түлшний хэрэглээг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

Дараа 7 хоногт нь 3 дахь дэд хэлэлцүүлэг 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Утааны асуудал, эрх зүйн орчин, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага сэдвээр 3 дахь хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар удирдан явууллаа.

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг товч үзвэл 2018 оноос эхлэн улсын төсвийн бодлогод агаарын бохирдол гэсэн тусгай арга хэмжээг үүсгэн хөрөнгө төсөвлөсөн. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 2018-2025 он, Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр батлах тухай 2017 оны 98 дугаар тогтоолын хүрээнд 2018-2024 он, Улсын төсвөөс нийт 336,1 тэрбум төгрөг төсөвлөж, үүнээс 276,3 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл нь 82,2 хувьтай байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зардал 243,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Цэвэр агаар санг байгуулсан бөгөөд энэ хүрээнд жилдээ 5-30 тэрбум хүртэлх төгрөгийг зарцуулж, өнгөрсөн хугацаанд нийт 111,9 тэрбум төгрөг зарцуулжээ.

Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт, урамшуулал, зээлийн хүүгийн татаасын хүрээнд агаарын чанарын бүсэд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт, ногоон зээл, татааст 2019-2024 онд нийт 46,1 тэрбум төгрөг, Агаарын чанарын бүсэд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн нөлөөллийн арга хэмжээнд нийт 36,1 тэрбум төгрөг, Орчны бохирдлыг бууруулах ажлын ал албаны үйл ажиллагааны зардалд 2,4 тэрбум төгрөг, Нийслэлийн агаарын чанарын бүсэд чиглэсэн төсөл арга хэмжээний зардал 44,6 тэрбум төгрөг, Орон нутаг агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн төсөл арга хэмжээний зардал 12,3 тэрбум төгрөг, Тавантолгой түлш ХХК-д сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой санхүүжилт нь 67,8 тэрбум, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт борлуулалт, хадгалалттай холбоотой санхүүжилт 37,2 тэрбум, Шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Өвөрхангай аймагт 4,3 тэрбум төгрөг. Хяналт шалгалтын хүрээнд агаарын чанарын бүсэд түүхий нүүрс оруулахыг хориглох тухай тогтоолын хэрэгжилтийг хангуулж, агаарын чанарын

бүсийн дэглэмийг мөрдүүлэх 16,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож зарцуулсан.

Халаалтын зуухыг төвлөрсөн дулаан хангамжид холбосноор түүхий нүүрсний хэрэглээг 204,6 мянган тонноор, нүүрсхүчлийн хий 547 мянган тонноор буурсан. Хэрэглэгчийн шөнийн тарифыг хөнгөлснөөр гэр хорооллын аль өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтөд хамруулснаар иргэд цахилгаан халаагуур ашиглах санхүүгийн боломж бүрдсэн гэсэн дүгнэлт гарсан байна.

4 дэх хэлэлцүүлэг 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Утааны асуудал, зуух, түлшний технологийн шийдлүүд сэдвээр 4 дэх хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргал удирдан явуулсан.

Тус хэлэлцүүлэгт нийт 70 иргэн оролцсон болон 28 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөлөл өөрсдийн шийдэл, шинэ санаачилга, бүтээлээ танилцуулсан. Хэлэлцүүлэг танилцуулсан мэдээллийг товч танилцуулбал, Утаа бууруулах технологийн шийдлийг төрөөс сонгохгүй, иргэд өөрсдөө сонгох боломжийг олгох хэрэгтэй. Төрөөс зөвхөн утаа гаргах байх шаардлага тавиад, хөнгөлөлттэй зээл санал болгох шаардлагатай. Гэр хороолол хэсэгчилсэн болон бие даасан дэд бүтцийн шийдлийг дэмжих дулаан, цахилгаан станцууд барих, шахмал түлшний түүхий эд болох мидлинг сольж, үзлэг багатай сайн чанарын нүүрс ашиглах. Гэхдээ хагас кокс, хөх нүүрсний үйлдвэрлэлд хөрөнгө зарцуулахаас зайлсхийх, цахилгаан халаалт ашиглах, нүүрсний хийн түлш үйлдвэрлэх мега төслийн танилцуулга болон бусад эх үүсвэрүүдийн хийн түлшээр хангах, сайн дулаалсан барилгыг нарны энергиэр халаагч жишээ модлог био түлш ашиглах боломж, Цэвэрлэх байгууламжийн шугамын урсгал, дулааны насос ашиглан дулааны станц барих, нарны дулааны коллектор, дулааны насосоор байшин халаах шийдлүүд, дулааны нөөцөөр цахилгаан халаагуур гэр байшинд ашиглах талаар, хүндийн хүчний цахилгаан станцын технологийг ашиглахад Засгийн газраас буцалтгүй тусламжаар үйлдвэрлэлийн зардлыг гаргаж, өргөн хэмжээнд бодлогоор түгээх боломжийн талаар, Аэрогель, будаг, түрхлэг зэрэг орчин үеийн дулаан тусгаарлагч супер материалуудыг ашиглаад гэр байшин дулаалах шийдлүүд, Улаанбаатар хотод хэд хэдэн байршилд 150 метр өндөртэй цамхаг байгуулаад агаарыг нь сороод шүүгээд, дээш нь өндөр гаргаад нөлөөллийг нь бууруулах шийдлийг Оюутолгойн далд уурхайн босоо амтай харьцуулж хийсэн шийдлийн танилцуулга зэрэг танилцуулагдлаа.

2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд Төрийн ордонд агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого, шийдвэр, хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2 дахь хэсэгт заасны дагуу ерөнхий хяналтын сонсгол явуулах талаар зар мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонсголд оролцогчдыг бүртгэлээ. Сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна төрийн бус байгууллагын төлөөлөл 6, иргэд 94, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл буюу шууд дамжуулж байгаа 2 телевиз, нийт 104 оролцогч бүртгэснээс төрийн байгууллагын төлөөлөл 64, Төрийн бус байгууллагын болон иргэдийн төлөөлөлд 46 оролцсон болно.

Сонсгол дараах дүгнэлтийг танилцуулсан. Үүнд:

Агаар бохирдлын хүн амын эрүүл мэнд, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Эрдэнэболд 1 дүгээр хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг анагаах ухааны доктор, дэд профессор, орчны эрүүл мэндийн судлаач Б.Сувд танилцуулсан.

2 дахь илтгэл Стандарт, хяналт, зуух түлшний технологи сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан, танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-аас үзэж болно. 2 дугаар хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг шинжлэх ухааны доктор Нарангэрэл.

Эрх зүйн орчин, бодлого, шийдлийн хэрэгжилт, санхүүжилт, зарцуулалт, хариуцлага сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар танилцууллаа. Хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг шинжээч Эрдэнэчулуун, Жавхлан нар танилцуулсан.

Зуух түлшний технологийн шийдлүүдийн талаарх уулзалт хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргал мэдээлж та бүхэнд танилцууллаа.

Сонсголд оролцогчоос илэрхийлсэн санал, мэдээлэл, дүгнэлтийн талаар та бүхэн тайлангаас уншчихаарай. Би шууд 2 хэлэлцүүлгээс гарсан ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Сайжруулсан түлшний хэрэглээний холбоотой Хүн амын эрүүл мэнд, амь насанд угаартах аюул учирсаар байх тул угаарын хий мэдрэгчийн айл бүхэнд байршуулах, Тавантолгой түлш ХХК, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас айл бүрийн эрсдэлийг үнэлж, арилгах,

2.Эрүүл мэндийн яамны зүгээс агаарын бохирдолд өндөр эрсдэлтэй, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэнд угаартаж амь насаа алдсан нийт хүн амын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлээс сэргийлэх, хамгаалах ажлыг нотолгоонд тулгуурлан эрчимжүүлэх, төлөвлөгөө боловсруулан зорилтот хүн амд хүрч ажиллах, эмнэлгийн бэлэн байдлыг ханган ажиллах,

3.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид утаа, агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулах асуудалд хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх. Энэ 3-тай холбоотой асуудал дээр бид бол Улсын Их Хурлын тухай хуульд байнгын үйл ажиллагаатай, утааны асуудалтай холбоотой дэд хороо байгуулах асуудлыг бол ажлын хэсгийн гишүүд бүгд санал 1-тэй дэвшүүлж байгаа. Тэгээд энэ дээр Байнгын хороондоо чиглэл өгөх, энэ дээр байнгын хорооноос гарах тогтоол дотроо энд оруулна аа гэж бодож байгаа.

4.Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр ялангуяа буулгасан иргэн, аж ахуйн нэгжүүдэд урамшуулал олгох үйл ажиллагааг явуулах,

5.Цаашид нийслэлийн хатуу түлшний хэрэглээнээс гаргаж хийн түлшний хэрэглээ нэвтрүүлэхдээ ахуйн орчин нөхцөлд нь эрсдэлийн болон өртөг, үр ашгийн үнэлгээг хийж нэвтрүүлэхэд анхаарах,

6.Гэр болон барилга байгууламжийн дулааныг нэгдсэн стандарт боловсруулан батлуулж дулааны шинэ технологи нэвтрүүлж буй аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээ салбарын яамны зүгээс авч хэрэгжүүлэх мөрдүүлэх,

7.Орон нутаг бүр Агаарын тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах, хүн амыг агаарын бохирдлоос хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх,

8.Салбарын яамны зүгээс орон нутагт агаар бохирдуулагч бүрийг хэмжих чадавхыг бий болгож, хатуу түлшний хэрэглээ халах бодлого боловсруулах гэсэн санал, дүгнэлт гарчээ. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ж.Батжаргал: Чинбүрэн гишүүнд баярлалаа. Тайлантай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Идэрбат гишүүнээр, Наранбаатар гишүүнээр тасаллаа. Мөнхбат гишүүнийг нэмээд оруулчихаарай. Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ өвөл яг л өвөл болгон л яригддаг энэ утааны асуудал дээр бас Улсын Их Хурал сонсгол зохион байгуулж, энэ сонсголоор тодорхой болсон нөхцөл байдалд засаж залруулах талаар Засгийн газрын тогтоол чиглэл өгүүлэх гээд байна л даа. Тэгээд би энэ Засгийн газрын өгөх чиглэл дотор хэд хэдэн зүйлүүд дээр бид бас жоохон зарчимтай баймаар юм шиг санагдах юм. Жишээ нь энэ тогтоолын төслийн 1 дээр угаарын хий мэдрэгчийг гэр хорооллын айл бүхэнд байршуулах, тогтмол ажиллагааг хянах. Энэ тэгээд Засгийн газрын үүрэг, төрийн үүрэг юм уу. Тухайн тэр айлд тэр утаа мэдрэгч нь ажиллаж байгаа эсэхийг тэгээд 1 төрийн албан хаагч хянаад явах юм уу. Ер нь өөрийнхөө гэр бүлийн амь насыг эрсдэлээс хамгаалах үүрэг нь иргэн хүндээ өртэй байх ёстой юм биш үү. Тэгэхгүй одоо нөгөө батарей нь суучихсан юм. Ажиллахгүй байгаа юм. Хорооноос ирж сольж өгөх л байлгүй дээ гэдэг шиг. Тэгэхээр би бол энэ Засгийн газрын тогтоол дээр хувь хүний өөрийнх нь үүрэг хариуцлагатай холбоотой зүйлийг бид бас өөрсдөд нь чиглүүлэх хэрэгтэй байх гэж ингэж бодож байгаа юм.

Дараагийнх нь энэ нөхөн төлбөр олгоно гэсэн ийм зүйл бас явж байх юм. Яг тийм нөхөн төлбөр олгох эрх зүйн орчин, яг тийм боломж бололцоо бидэнд бас байгаа юм уу. Одоо бас хэтэрхий ингээд энэ утааны асуудал нийгмийн хурц асуудал гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ хэтэрхий бас хүнд таалагдахын тулд хүний өөрийнх нь хийх юмыг төр өмнөөс нь хийх гээд байгаа юм шиг ийм зүйл байх нь хэр зохимжтой юм бол. Энэ тогтоолын хэрэгжилт гэдэг чинь бас байх ёстой шүү дээ. Тэгэхээр би бол энэ мэдрэгчид зориулж байгаа, тэр яндангаа хөөлнө. Янданг нь төр хөөлж өгнө энэ тэр гээд хөдөөгийн мань мэт сонсвол инээд хүрмээр юмнуудыг төр хийгээд яваад байгаа байхгүй юу. Тэрэнд зориулж байгаа эх үүсвэрээ тэгвэл тэр гэр хорооллоо яндангаа цөөлөөд, цахилгаанаар халааж байгаа тэр өрхүүд рүүгээ энэ дулааны хангалтыг сайжруулахад тэр ноосоор дулааны барилгын материал үйлдвэрлэх тийм юм руугаа тэгээд нийслэлийн нэг хийн түлш энэ тэр гээд байгаа ийм юм руугаа хэдүүлээ чиглэхгүй бол нийслэл

тэнд нэг өөр юм яриад, эндээс нэг шал өөр тогтоол гаргаад, дундаа хаяад, тэгээд эргээд л дахиад л утааны асуудал гээд л яриад сууж байх вий. Тэгэхээр би энэ тогтоол дээр ... /минут дуусав/

Ж.Батжаргал: Гишүүд ээ, тогтоолтой холбоотой асуудал нь 2 дахь асуудал хэлэлцэж байгаа. Гэхдээ манай ажлын хэсэг нөхцөл байдалдаа бодитой дүгнэлт хийж, мэргэжлийн байгууллагуудынхаа мэдээлэл, бүх юмыг сонсоод, тэр дээр тулгуурлаж тов тодорхой санал дүгнэлт орж ирсэн. Тэгээд энэ талаасаа Чинбүрэн гишүүн хариултыг өгье. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ер нь Тавантолгой түлш ХХК нийслэлийн өмчлөлд ирсэн. Мөн нийслэлийн иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ерөөсөө л энэ сайжруулсан түлш сайжрах тусам л үнэр нь багасаж, угаарын хийн хэмжээ ихсэх аюул, үүнийгээ мэдрэхгүй байж байгаад шөнө угаартаж үхсэн олон олон харамсалтай тохиолдлууд байгаа. Үүнийг давж гарах хамгийн чухал зүйл бол ерөөсөө л утаа мэдрэгч ажиллагаатай байх л асуудал. Хэлэлцүүлгийн явц бусад бол зарим нэг мэдээлэл фактуудыг харахад зарим нь бүр гэртээ тамхи татаад дуугардаг учраас дууг нь хаачихсан, доторх батареийг нь авчихсан, авдартаа ороогоод далд хийчихсэн ч гэх мэтчилний ийм иргэдийн өөрсдийн хариуцлагын асуудал нэлээн яригдсан үнэн. Гэхдээ одоо бид бас иргэдээ сэрэмжлүүлж анхааруулж, байнгын бэлэн байдлыг нь хангаж, шалгаж байхгүй л бол энэ угаартаж эндэх асуудал бол ерөөсөө зогсохгүй.

Энэ утгаараа бас нийслэл “Тавантолгой түлш” ХХК дээр 1 том дэвшил гарсан нь утаа мэдрэгч нь өөрөө мэдээллээ дамжуулж ажиллаж байгаа байдлыг нь том биг датагаар Тавантолгой түлш ХХК дээр хянах рийл тайм дашбоард ажиллах боломжтой болчихсон юм байгаа юм. Тийм учраас шинэ технологиудаа яаралтай суулгах, дээрээс нь 45 мянга гаруй өрх утаа мэдрэгчгүй байгаа энэ тэрээ гүйцээх, хурдлах, үүнийгээ тогтмол үйл ажиллагааг нь хянах чиглэлд бид бас оролцохгүй бол үнэхээр болохгүй байна. Үнэхээр болохгүй байгаад байна. Ингээд энийгээ мэддэггүйгээс соён гэгээрүүлэх үйл ажиллагаа дутуугаас болоод энэ хариуцлагын асуудал үнэхээр бас ярихгүй бол болохгүй байна.

Тийм учраас эрдэнэт хүний амийг аврахын тулд төр, ялангуяа өөрийнхөө нийслэлийн бүтцээрээ дамжуулаад, хороодын нийгмийн ажилтнуудаараа дамжуулаад, доошоо салаалаад, хэвтээ байдал дээрээ иргэдийнхээ аюулгүй байдал, айл өрхийн аюулгүй байдал дээр анхаарч сургаж байх нь бол яалт ч байхгүй л бид нар хийхээс өөр гарцгүй ажил болж байна.

Нөгөө сая Байнгын хорооны даргыг орлож байгаа Батжаргал гишүүний хэлснээр бид Засгийн газарт өгөх чиглэл дотроо энэ эрх зүйн тухай ярьж байгаа шүү. Нөхөн олговрын асуудлыг бид шууд олгох боломжгүй. Харин зүгээр Монгол Улсад одоогоор яг хохирсон иргэдийн нөхөн олгох эрх зүйн орчин ерөөсөө байхгүй байна. Дээрээс нь бид бас ямар тохиолдолд ингэж угаартаж эндсэн асуудлыг бүр нарийн задалж, нотолгоо гаргаж ирэх бас ажлууд дутуу байгаа. Энэ бүгдийг хийгээд, харин цаашдаа бид ер нь агаарын юутай холбоотой угаартсан, ялангуяа ахуйн угаартай холбоотой энэ асуудлыг бид ер нь цаашид яаж шийдвэрлэж байх юм гэдэг энэ эрх зүйн орчныг хийж өгөх ажил бидний үүрэг болж байна л гэж харж байгаа юм.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм ээ. Нөхцөл байдлыг нь ч ойлгож л байгаа. Гэхдээ төр нь хариуцах юмаа хариуцаад, иргэн хүн нь бас хариуцах үүргээ биелүүлэх үүргээ биелүүлээд, Засгийн газраас, нийслэлээс энэ утааг бид нар яаж байхгүй болгох, утаа янданг яаж цөөлөх гэдэг тэр гол зорилго руугаа мөнгөө, хөрөнгөө зарцуулаасай л гээд байгаа байхгүй юу. Би сая энэ утаа мэдрэгчийг сая үг хэлэхээсээ өмнө үнэ ханшийг нь судаллаа. 40 мянга. Гэтэл энэ чинь нийслэлээс гарч байгаа төсөв нь бол тамтаггүй их юм гараад байдаг. Нэгж айл дээрээ ийм цөөхөн юм оччихдог. Тэрний оронд энэ гарч байгаа төсөв, тэр яндан хөөлж байгаа төсөв энийгээ тэр тогоор цахилгаан халааж байгаа айлууддаа, хийн түлш тавьж байгаа айлууддаа ийш нь чиглүүлэх Засгийн газарт хэрвээ чиглэл өгөх гэж байгаа бол бид энэ талынх нь юмыг бас дэмжиж явах .../минут дуусав/

Ж.Батжаргал: Санал хэлчихлээ. Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ өдрийн мэнд хүргэе. Энэ сонсгол хийх ажлын хэсэгт би өөрөө байсан л даа. Тэгээд одоо ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлт гэдгийн 1 дүгээрт байна. Сайжруулсан түлшний хэрэглээтэй холбоотой хүн амын эрүүл мэнд, амь насанд угаартах аюул учирсаар байх тул угаарын хий мэдрэгчийг айл бүхэнд байршуулах гэж байгаа байхгүй юу. Энэ чинь хүн ардаа угаартуулдаггүй түлш хийж болохгүй юм уу. Угаартуулдаг түлш хийнэ. Тийм учраас айлуудад угаарын хий мэдрэгч тавь гэдэг чинь арай л хэтэрхий байна шүү дээ.

Дээрээс нь иргэдээс оролцож санал, хүсэлт хэлж байхад ингэж байсан. Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож өгөөч ээ. Бид нар өнөөдрийг хүртэл энэ Улаанбаатар хот хорт утаатайгаа, агаарын хийн бохирдолтойгоо байна гэсэн. Энэ санал, дүгнэлт дээр холбогдох ямар ч албан тушаалтанд хариуцлага тооцсон зүйл алга. Хэлэлцүүлгийн явцад мидлинг болон хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлшний техникийн үзүүлэлтүүдийг бид нар харьцуулж хийсэн. Энэ нь байна шүү дээ, тухайн үед хэлэлцэж байхад эрдэмтдийн илтгэл дотор хортой бодис ялгаруулсаар байсан. ПМ10, ПМ2,5. Гэтэл энд дандаа ингээд сайжруулсан гээд явчихсан байх юм. Хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлш техникийн үзүүлэлтийг харьцуулахад хагас кокс нь сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр агаарын чанарыг сайжруулахад шууд нөлөө үзүүлсэн нь туршилтаар батлагдсан гээд.

Тэгээд бас нэг зүйл ажиглагдаж байсан. Эрдэмтэд нь өөрсдийнхөө цагаан цаасан дээр хараар бичсэн юмнаасаа асуулт асуухаар буцчихаад байсан л даа. Тэгэхээр бид нар заавал ард түмнээ ингэж хордуулдаг юмыг нь авч тавьчихаад, хүлээн зөвшөөрчхөөд, тэгээд угаарын хий мэдрэгч тавь, иргэд өөрсдөө угаартаж үхэхгүй хариуцлагатай бай гэсэн юм шиг санагдаж байна. Энийгээ эргэж хараач ээ.

Тэгээд хариуцлага тооцсон нь хаанаа байна. Хагас коксожсон түлш түлш чинь технологийн алдаа гаргасан байсан. Ийм асуултууд байна. Нэмж тодруулаад явъя.

Ж.Батжаргал: Хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Ер нь угаартуулсан түлш хийсээр байх уу гэдэг асуудалд их чухал асуудал хөндлөө. Тэгэхээр бид бас утааны асуудалтай холбоотой ерөнхий сонсголын үед гол ярьж байгаа зүйл бол үндэсний агаар, бохирдолтой тэмцэх

хорооноос гаргасан хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд бол эхний удаадаа түүхий нүүртнээсээ салах том зорилго нь энэ сайжруулсан түлш, дараагийнх нь болохоор коксожсон нүүрсээр ашиглах, бүр дараагийнх нь бол хатуу түлш хэрэглэхгүй байх гэсэн ийм том зорилтыг 2025 он гэхэд хэрэгжүүлээд эхэлчихсэн. Хэрвээ энэ үйл ажиллагаа зөв явсан байсан сан бол өнөөдөр бид хатуу түлшний энэ асуудлаа ярихгүй болчихсон байх ёстой байсан. Тэгэхээр цаг хугацаандаа ажлуудаа хийж чадаагүй явдлыг бид бас энэ сонсголын үеэр илчилсэн. Химийн хүрээлэнгийн шинжээч нар бол түүхий нүүрс өөрөө ямар муу байсан, сайжруулсан түлш бол сайжирсан гэдгийг тоо баримтаар яриад байсныг та бүхэн мэдэж байгаа.

Зүгээр харин бид энэ ерөнхий сонсголын явцад нэг нотолсон зүйл юу байсан гэхлээр шахмал түлшнийхээ стандартыг барьцалдуулагчдадаа зориулаад буулгачихсан ийм зүйл байсан шүү. Нэг ёсондоо муу түлшиндээ тааруулж стандарт баталчхаад, тэр стандартын дагуу нийцэж байгаа гээд хэв нэг яриад зогсож байсан. Энэ нь бол өөрөө гэмт хэргийн шинж чанартай зүйл байсан. Яах вэ зүгээр ерөнхий хяналтын сонсгол бол өөрөө бид илүү их нотлох баримт бүрдүүлэх боломж бас сул байсан учраас манай ажлын хэсгийн нэлээн олон гишүүдээс бүр хяналтын түр хороо байгуулж, энийг үнэхээр нотлох баримт цуглуулж, гэмт хэргийн шинж чанартай байсан уу, ашиг сонирхлын зөрчил юу байв, авлигын асуудал үүний ард байсан уу, мөнгө шамшигдуулах үйл ажиллагаа явсан уу гэдгийг бас дахин нотлох баримтаар ил гаргах боломжийг бүрдүүлье гэдэг санаачилгыг гаргаж байсан. Тийм учраас Их Хурлын гишүүдийн өөрсдийнх нь бүрэн эрхийн хүрээнд байгаа асуудлаар цаашдаа хяналтын түр хороо байгуулж, илүү нотлох баримт цуглуулж ажиллах энэ боломж нь нээлттэй байгаа гэдгийг хэлье.

Тэгээд энэ дүгнэлт дотор бас хэлэлцсэн зүйлүүд байгаа. Цааш нь үргэлжлүүлээд харах юм бол энэ стандартаа яаралтай шинэчлэхгүй бол энэ бол үйлдвэрлэлдээ зориулсан стандарт гэж юу байх вэ дээ. Тэгэхээр бол агаарын бохирдолгүй байх стандартаа түүнд тохируулж түлшээ л үйлдвэрлэх ёстой болохоос ингэж иргэдийнхээ төлөө эсрэг ийм гэмт хэргийн шинж чанартай зүйл хийж болохгүй. Ингээд хэдүүлээ бас гарч байгаа Засгийн газарт өгөх дараагийн хэлэлцэх асуудал дотроо энэ асуудлууд дээрээ илүү анхаарч бас найруулгын шинж чанартай нэмэх зүйл байвал та бүхэн нэмж хэлээрэй. Баярлалаа.

Ж.Батжаргал: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Тэгэхээр ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлтийн 1 дүгээрт байгаа сайжруулсан түлшний хэрэглээтэй хүн амын эрүүл мэнд, амь насанд угаартах аюул учирсаар байх тул гэдгийг бид ерөөсөө хүлээн зөвшөөрч болохгүй. Хүн амынхаа эрүүл мэнд, амь насанд угаартах боломж нь байсаар байгаа тул угаарын хий мэдрэгчийг айл бүхэнд байршуулах гэдэг чинь дахиад нэг бизнесийг дэмжих гэж байгаа юм. Тэгэхээр хүн ардынхаа амь насаа алдаж байгааг хүлээн зөвшөөрчхөөд, дээрээс нь угаарын хий мэдрэгч тавих бизнесийг 1 дүгээрт дэмжиж болохгүй. Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчийн хувьд энд анхаарч, үүнд өөрчлөлт оруулж өгөөч.

Агаарын бохирдол яагаад өнөөдрийг хүртэл байгаад байсан бэ гэвэл тэр муу, буруу хийсэн сайжруулсан түлшнийхээ стандартад зориулж стандарт баталсан. Уг нь эхлээд стандартаа баталчхаад, тэрэндээ тохируулж бид нар сайжруулсан

түлшний мидлингээ хийх ёстой байсан. Тийм үү. Тэгэхээр энэ стандартыг .../минут дуусав/

Ж.Батжаргал: Санал байна. Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Агаарын бохирдол гэдэг асуудал бол зөвхөн Улаанбаатар хотын асуудал биш л дээ. Аймаг, орон нутаг, аймгийн төвүүд, зарим томоохон сумуудын хэмжээнд бас нэлээн хурц асуудал болчихсон ийм асуудал байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсэг байгуулагдаад Чинбүрэн гишүүнээр ахлуулаад бас тодорхой ажлуудыг, хэлэлцүүлгүүдийг бас хийж зохион байгуулж санал, дүгнэлт боловсруулж, тайлангаа тавьж байгаад талархаж байна. Тайлангийн санал, дүгнэлтийн 12, 13 дахь хэсгүүдээс бас тодруулж асууя гэж бодож байгаа юм. Тэгээд энэ 2 чинь ерөнхийдөө хоорондоо ялгаагүй 1 л зүйл юм шиг байгаа юм. Хэмжих асуудал байгаад байгаа юм. Агаар бохирдуулагчийг хэмжих асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр 12-т нь орон нутаг бүр агаарын тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлж, агаарын бохирдлыг хэмжих тоног төхөөрөмжөөр яаралтай хангах гээд аймаг сумууд бол ер нь агаарын бохирдлыг хэмждэг ийм тоног төхөөрөмжтэй байгаа шүү дээ. Хангагдчихсан байгаа. Тэгээд энэ айл өрхүүдийг хангах асуудал яригдаад байна уу, аль эсвэл олон аймаг, сум хангагдаагүй үлдчихсэн байгаа юм уу гэдгийг нэг тодруулчихмаар байгаа юм.

Бас энэ салбарын яамны зүгээс орон нутагт агаар бохирдуулагч бүрийг хэмжих чадавхыг бий болго гээд байгаа юм. Энэ нь юу гэсэн үг юм бол. Тоног төхөөрөмж байгаад ажиллах боловсон хүчнийг нь чадавхыг бий болгох асуудал яригдаж байна уу. Аль эсвэл техник тоног төхөөрөмжийн асуудал яригдаж байгаа юм уу. Тэгэхээр 12, 13 дахь санал, дүгнэлт чинь хоорондоо ямар ялгаатай байгаа юм бол. Яг ямар утга агуулгатай ийм санал. дүгнэлт юм бол гэдгийг бас асууя гэж бодсон юм.

Тэгээд ер нь аймгийн төвүүд бол сүүлийн үед маш их агаарын бохирдолтой байгаа. Хэлэлцүүлэг дээр хэрхэн судалгаа тайлан яригдсан юм бол. Хамгийн их агаарын бохирдолтой аймаг ямар аймаг байна вэ.

Мөн зарим сумууд, ялангуяа уур уурхайтай Цогтцэций мэтийн сумууд бол маш их агаарын бохирдолтой. Утаа дээрээс нь нэмээд уул уурхайн нөлөөллөөс гарч ирж байгаа цагаан тоосны асуудал гээд ингээд нөгөө Үндсэн хуульд заасан эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллаж хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсөн ийм сумууд байна. Тэгэхээр энэ тухай энэ сонсгол дээр яригдсан, судалсан ийм зүйл байна уу. Цаашдаа яах ёстой вэ. Яаж агаарын бохирдлыг бууруулах ёстой вэ гэдэг дээр тодруулга авъя.

Ж.Батжаргал: Чинбүрэн гишүүн хариулъя ер нь ихэнх нь санал байв уу.

Ж.Чинбүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Та бас яг зөв юу хэлээд байна. Улаанбаатар нийслэлийнх нь болохлоор түүхий нүүрснээсээ салаад, ингээд сайжруулсан түлш рүү ороод байдаг юм уу. Бусад аймгуудад амьдарч байгаа, суурин газар амьдарч байгаа иргэд тэгээд бас дахиад л түүхий нүүрсээр хордсон хэвээрээ л байгаа. Тийм учраас энэ асуудал бол Монгол Улсын асуудал юм. Ганцхан нийслэлийн асуудал биш юм гэдэг талаасаа бид бас ажлын хэсгийнхэн ажиллаж, энэ чиглэлд бас асуудлыг хандуулж байсан. Үүнтэй холбоотой Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас мөн Одонтуяа

сайдаас хэлж байсан зүйл бол орон нутагт агаарын тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд энэ агаарын бохирдлыг хэмжих тоног төхөөрөмж хангалттай биш байна гэдгийг хэлж байсан. Сая бас 2025 оны төсөвт суулгасан боловч хасагдлаа. Тэгээд орон нутаг бүрд энэ аймаг сумуудад агаарын бохирдлоо хэмжиж чадахгүй бол бид үйл ажиллагаа явуулж чадахгүй. Юунаас бохирдоод байгаагаа ялгаж чадахгүй болохоор Агаарын тухай хуулийн хэрэгжилтээ ч хийж чадахгүй. Үнэхээр бохирдсон, үгүйгээ хэлж чадахгүй байгаа явдал нь энэ 12 дугаар дүгнэлтийг гаргах чухал зүйл болж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө бид хэмждэг байх нь өөрөө их чухал юм байна лээ. Тэгээд энэ утгаараа бүх суурин газруудаа агаарын бохирдлыг хэмждэг, дээрээс нь боловсон хүчний, тэнд ажиллах хүний нөөцийн гээд л асар олон асуудлууд хаалттай. Таны сая хэлж байгаагаар зарим газар бол ганцхан утааны асуудал биш байхгүй юу. Тоосжилтын асуудлууд, зөндөө олон зүйлүүд байна. Тэгэхээр энэ болгон дээр үйл ажиллагааг Үндэсний хороо явуулахад энэ хэмжилтийг хийдэг байя гэдэг асуудлыг ярьсан учраас Засгийн газарт энэ дүгнэлтийг оруулж, мөн Засгийн газарт дараагийн хэлэлцэх асуудал дотор бол энэ төсөв төлөвлөх асуудлыг ярьж байгаа юм.

13 дахь зүйл нөгөө яамны зүгээс орон нутагт агаар бохирдуулагч бүрийг хэмжих чадавхыг бий болгож, хатуу түлшний хэрэглээг халах гэж байгаа. Энэ юу бол сая хэлсэн зүйлтэй бас холбоотой. Хэмжиж чаддаг байя. Тэгээд ялгаагүй л бид бас түүхий нүүрснээсээ л ер нь хамгийн түрүүнд салах нь өөрөө маш чухал байсан. Ер нь бол түүхий нүүрс түлэхэд ямар их хортой армат нэгдлүүд, дээрээс нь бусад хортой бодисууд гарч байгаа, үүнтэй холбоотой хүний эрүүл мэндэд яаж муугаар нөлөөлж байгаа гэдгийг бол бид дэд хэлэлцүүлгийн явцад үнэхээр сэтгэл өвдөм мэдээллүүдийг сонсож байсан. Зүгээр л энгийн жишээ гэхэд л эмэгтэйн хэвлийд бүрэлдэж байгаа ураг хүртэл грамм нь хүртэл бага байдаг. Дутуу төрдөг. Жирэмслэлтийн тохиолдлын тоо цөөрдөг гээд л өвлийн утаатай нийслэлийн асуудал бол ганцхан, зөвхөн эдийн засгийн ч асуудал биш, эрүүл мэндийн хувьдаа бол үнэхээр ноцтой асуудал байсан. Тийм учраас энэ түүхий нүүрснээс салж чадаж байгаа нь өөрөө их том амжилт. Харин энийгээ бүр цааш нь хурдацтай сайн явуулах чиглэл дээр л анхаарах хэрэгтэй юм байна л гэсэн ийм дүгнэлт гарч байсан.

Ж.Батжаргал: Мөнхбат гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхбат: Манай утааны эсрэг хяналтын сонсгол зохион байгуулах ажлын хэсэг маань ажиллаад бас тодорхой дүгнэлтүүдийг гаргасан байна. Энэ дотроос ганц 2 юм бас сонирхож тодруулж асууя гэж бодож байна.

Монгол Улсын Ерөнхий сайдаар Хүрэлсүх сайд ажиллаж байх үед нэг хэсэг утаа бас гайгүй болсон. Тийм кэйс байгаа. Тэр үед бол түүхий нүүрсийг бүрэн хориглоод, шахмал түлшийг нэлээн сайн эрчимтэй үйлдвэрлээд явуулж байсан. Шахмал түлшийг орон нутгаар Өмнөговь, Дундговийн замаар нүүрсний тэр мидлинийг зөөсөөр байгаад замыг бүрэн эвдээд, өнөөдөр нөгөө замаа засах гээд 150 хэдэн тэрбум төгрөгийн өртөгтэй болчихоод байгаа юм. Тийм үр дагавар бий болгоод, тийм хохирол энэ авто зам дээр үзүүлчхээд, өнөөдөр нөгөө утаа нь эргээд нэмэгдчихсэн. Энийг ер нь юутай тайлбарлаж ойлгож үзэв. Нөгөө түүхий нүүрсээ буцаагаад бид нар оруулаад хэрэглээд үзчихэв үү. Тэр шахмал түлшнийх нь найрлага юм нь буруу болоод, буцаагаад утаатай болчихов уу гэдэг дээр манай ажлын хэсэг маань ямар дүгнэлт хийв гэж 1 дүгээрт асуумаар байгаа юм.

2 дугаарт хэрвээ технологийн горим юм нь алдсан бол хэрвээ нөгөө шахмал түлшээ үйлдвэрлэх хүчин чадал нь алдсан бол энэ боловсон хүчин, хүний нөөцөд байна уу. Хаана энэ хариуцлага юмнууд нь алдагдав гэдэг дээр ямар л дүгнэлт хийв гэдэг бас нэг зүйл.

3 дугаарт одоо бид нар энэ хатуу түлшийг халаад, өөр халаалтын системүүдийг нэвтрүүлж гээд үзэж байгаа юм. Магадгүй хийн шугам тавих ч юм уу өөр юу юу байдаг юм. Энэ нэвтрэхэд ямар цаг хугацаа орохоор байна гэдэг дээр та бүхэн маань ямар дүгнэлт хийв гэдэг ийм 3 асуултыг асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хариулъя Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Та үнэн хэлж байна. Яг 2019-2020 он, 2020-2021 оны өвөл, тэгээд ковид цар тахал гарсан иргэд гэр орондоо гадагшаа гарч чадахгүй, дээрээс нь түлшний хэрэглээ өвлийн цагт бас нэлээн их байсан. Энэ үед бол үнэхээр агаар цэвэрхэн байсан. Үнэхээр тунгалаг болсон. Хөшиг татсан мэт болж дэвшил гарсан. Үүний одоо гол дэвшил юу байсан гэхлээр түүхий нүүрсээ нэгд больсон. 2-т Улаанбаатар хот руу орж ирдэг түүхий нүүрсний тээвэрлэлтийг хязгаарласан. Асар том хяналт тавьж чадсан. Цөөхөн хэдхэн зориулалтын том уурын зуухнууд л түүхий нүүрс хэрэглэх боломж цөөхөн хязгаартайгаар өгөөд, бусад бүх аж ахуйн нэгж, айл өрхүүд шахмал түлшээ хэрэглэж эхэлсэн.

Шахмал түлшний стандарт өөрчлөгдсөн тухай түрүүн хэлсэн. Тэгэхээр үйлдвэрлэл сайн явж байснаа нөгөө барьцалдуулагчдаа тааруулаад стандартаа бууруулсан нь том алдаа болсон. Түүхий нүүрсний хяналтыг Улаанбаатар хот руу оруулж ирэхгүй байх тэр хяналт байхгүй болсон. Дээрээс нь иргэд гэртээ гал түлж, гэрээ дулаацуулахдаа зөвхөн сайжруулсан түлш биш нөгөө дугуйны хаймар, нөгөө болохгүй болохгүй зүйлүүдийг түлдэг байсныг хянадаг байсан тэр тогтолцоо байхгүй болчихсон. Тэгээд одоо ингээд бүр та бүхэн ажиглавал зарим айлын яндангаас бүр хав хар айхтар үнэртэй утаа энэ тэр гарч байна шүү дээ. Тэр үед бол 5 мянга гаруй төрийн албан хаагчдыг бүр өвлийн цагаар бохир утаа гарсан яндан болгонтой айл руу нь очиж хяналт тавьж, түлшийг нь сольж байсан. Энэ бол их том соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж байсан. Энэ бүхэн энэ сайн туршлага байхгүй болсон. Нөгөө сайжруулсан түлш маань сайжруулсан биш муужруулсан болоод, доторх барьцалдуулагдаж байгаа стандартад буулгаад, тэгээд хийгээд эхэлсэн нь өөрөө чанарыг сулруулсан. Үйлдвэрийн процесст алдаа гарсан. Бид үйлдвэрүүд дээр нь очсон. Хатаалтын процесс. Бүрэн хатааж чадахгүй. жишээлбэл сайжруулсан түлш гээд байгаа нөгөө бөөрөнхий бөмбөлгийг газар унагаахад бутраад нөгөө элс шиг бутарч байгаа байхгүй юу. Энэ хэт их чийглэг ихтэй байгаа учраас ингэнэ. Хатчихсан сайн бөмбөлөг бол чулуу шиг так гээд л дуугарах ёстой байхгүй юу. Тэгтэл тэгэхгүй байсныг хүртэл бид үйлдвэрийн процесс дээр нь очиж үзлээ, харлаа. Алдаатай. Хатаах технологи нь өөрчлөгдсөн. Тухайлах юм бол хуучин бол хатаах технологи нь яг ийм хүйтний улиралтай оронд тааруулсан сайн хатааж чаддаг технологи хэрэглэж байсан чинь сүүлийн технологи нь яасан гэхээр зүгээр уураар хатаадаг болсон. Нэг ёсондоо нүүрс түлээд, тэр нүүрснээс ялгарч байгаа утааны дулаанаар дамжуулж, нөгөө шахмал түлшээ шахаад тэгээд хатаадаг. Тэр нь гүйцэт хатааж чадахгүй гэх мэтчилний ийм алдаанууд гарсан нь өөрөө их харамсалтай байлаа.

2 дахь асуултад хариулахад ер нь бид нэг ийм Засгийн газар залгамж халаа чанар бас алдагдсан зүйл байгаа. Тухайлах юм бол 2017-2021 оны хооронд Дэлхийн банкнаас 1,2 сая долларын өртгөөр Багануурын уурхайг хүрэн нүүрсийг хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулбал ТЭЗҮ нь ямар байх юм. Байгаль орчны нөлөөлөл нь ямар байх юм гэдэг судалгааг хийлгээд, тэр техникийн нөхцөл нь гарчихсан. Багануураас Улаанбаатар хот хүртэл шугам татаад .../минут дуусав/

Ж.Батжаргал: Чинбүрэн гишүүн гүйцээж хариулъя.

Ж.Чинбүрэн: Өвлийн улиралд илүү хийгээ үйлдвэрлээд, Улаанбаатар хот руу татсан хоолойгоороо хий нийлүүлэх, зуны улиралдаа илүү бензин үйлдвэрлэх ийм боломжтой судалгаа хийснийг би өөрөө үзлээ. Маш өгөөжтэй, тухайн үйлдвэр нь алдагдалгүй ажиллах ийм боломжтой ийм ТЭЗҮ хийгээд өгчихсөн. Байгаль орчны үнэлгээг нь хийгээд өгчихсөн ийм төсөл байж байхад үүнийгээ хэрэгжүүлээгүй суугаад байж байгаа нь одоо бид нар энэ муу түлшээ түлээд л байж байгаагийн нэг жишээ нь энэ. Хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд, хэдэн төгрөгийн ашигтай ажиллах боломжтой гэсэн ТЭЗҮ энэ тэр хийчихсэн. Би үүнийг бас Ерөнхий сайдад өөрт нь бас энэ төслийг бас танилцуулж өгсөн. Тэгэхээр энийг хэрэгжүүлээд явчих ийм бүрэн боломжтой, маш чухал ажил хийгдсэн байсан байна лээ шүү. Тэгээд энийг хийж чадах юм бол бас бид түргэн орж чадах байх.

Нийслэлийн Засаг дарга Нямбаатар бас дэд хэлэлцүүлгүүд .../минут дуусав/

Ж.Батжаргал: Мөнхбат гишүүн тодруулъя. Мөнхбат гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Мөнхбат: Яг саяын хэлсэн шиг бид нар энэ хийн системээ хэзээ угсарч гүйцэх юм. Ямар хугацаанд нэвтрүүлж амжих юм. Тэр хүртэл тэгээд энэ хатуу түлшээрээ л явж таарна. Энэ хатуу түлшээ тэгээд хэдүүлээ яах юм. Нөгөө шахмал түлшнийхээ стандартыг хуучин хэвд нь оруулах юм уу, эсвэл илүү сайжруулах тал дээр ажиллах ёстой юм уу гэдэг дээр манай ажлын хэсэг маань юу гэж дүгнэлт гаргав гэж асууя.

Ж.Батжаргал: Хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр цаг хугацааны хувьд бол Нийслэлийн Засаг дарга Нямбаатар бас оролцсон. Дэд сэдвийн хүрээнд ярилцахад бол ер нь энэ намраас бол шахмал түвшиндээ бид мидлинг ашиглахгүйгээр хүрэн нүүрс ашиглаж эхэлнэ. Илүү коксожсон сайн нүүрс ашиглах энэ үйл ажиллагаа эхэлж байгаа. 3 сарын 1-нд нөгөө мидлинг авахаа больсон гэдгийг бол хэлж байсан. Больж байгаа гэдгийг хэлж байсан. Одоо тэгэхээр больчихсон байх. Намрын хэрэглэх түлш нь бол арай сайжирсан байх юм байна гэж ойлгосон.

Мөн одоо хийн түлш ашиглах туршилтын ажлууд бол эхэлчихсэн. Нийслэлийн зарим бүсүүдэд яндангүй байх ийм тойрог бүсүүд гаргасан. Үүнтэй холбоотой бас хийн түлш ашиглаж, дулаан хоол хүнсээ хийдэг байх энэ туршилтын ажлууд нь эхэлчихсэн, нийлүүлчихсэн. Айлуудад хийж аюулгүй байдал, ашиглалтын үр нөлөөг судалж байгаа юм.../минут дуусав/

Ж.Батжаргал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо тайлантай холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Батчимэг гишүүнээр тасаллаа. Жаргалан гишүүн саналаа хэлье.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ өвөл ид утаатай байх үед Б.Мөнгөнхишиг тэргүүтэй хэсэг иргэдийн санаачилгаар гарын үсэг цуглуулж, бас Улсын Их Хурлаас утааны асуудлаар нийтийн сонсгол хийхийг шаардсан. Үүний дагуу бол тус Байнгын хорооноос Чинбүрэн гишүүн ахлагчтай ажлын хэсэг гарч, энэ утааны сонсголыг зохион байгуулсан. Өнөөдөр тайлангаа бас танилцуулж байна. Энэ хүрээнд бид бас олон зүйлийг харсан. Түүнээс хойш ч гэсэндээ миний хувьд иргэний нийгмийн байгууллагууд, энэ чиглэлээр ажилласан хүмүүстэй бас нэлээн уулзлаа. Тэгээд бидний зорилго бол энэ Улсын Их Хурлын зорилго бол 2028 оноос өмнө утааны асуудлыг дорвитой шийдвэрлэх улс төрийн манлайлал гаргах ийм зорилготой байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ бол бид бүхний хамтын манлайлал байх ёстой гэдэг дээр бол та бүхэн санал нэгдэнэ гэж ойлгож байна.

Тэгэхээр бол саяын утааны сонсгол бөгөөд энэ хугацаанд болсон үйл явдлуудыг харахад бид бол утааг шийдэх талаар даруй 20 жил ярьж байгаа юм байна. Анх 1995 онд Агаарын тухай хууль батлагдсан. 2001 онд утаа сайжруулсан зуухны талаар ч билүү дээ нэг ийм Засгийн газрын тогтоол батлагдаж байсан юм байна лээ. Өөрөөр хэлбэл 20 гаруй жил энэ утааг бууруулах санал санаачилгууд янз бүрийн элдэв янзын тогтоолууд гарч ажилласан юм байна. Тэгэхдээ харамсалтай нь өнгөрсөн хугацаанд бол бас яг энэ асуудал шийдэгдсэнгүй. Тэгээд 2 сарын өмнө болсон сонсголын хүрээнд бид өнгөрсөн хугацаанд 779 иргэн утаанд угаартаж амь насаа алдсан гэх мэтчилэн бол маш тийм сэтгэл сэртхийлгэм тоо баримтуудыг сонслоо.

Төсөв хөрөнгийн хувьд ч гэсэндээ ерөөсөө даруй 5 их наяд гаруй төгрөгийн зарцуулалт хийсэн гэсэн тооцоог бол бас бид манай ажлын албаныхан гаргасан байгаа. Тэгэхээр одоо хэдүүлээ дорвитой алхам хийх ёстой гэдэг дээр бол санал нэг байна. Тэгэхээр бол өнгөрсөн хугацаанд хэд хэдэн зүйл дээр бид нар сургамж авах ёстой юм гарсан юм уу гэж харж байгаа.

1 дүгээрт ерөөсөө ийм утааг бид нар богино хугацаанд бүрмөсөн шийдэж чадна гэсэн итгэл үнэмшил хаана хаанаа ажиглагдсангүй. Нэн ялангуяа нийтийн сонсгол дээр ирж ажлаа тайлагнаж байгаа төрийн албан хаагчдын хувьд ч гэсэндээ ерөнхийдөө тийм итгэл үнэмшил ерөөсөө байхгүй болчихсон байна. Тэгэхээр Улсын Их Хурал улс төрийн манлайлал гаргаад, Засгийн газар түүнд бас тэр чиглэлд ажиллаад, бид ерөөсөө энэ утааг шийднэ гэсэн тэр итгэл үнэмшлийг улс орноороо олж авах хэрэгтэй байна.

2 дугаарт ер нь бол утаанд мөнгө зараад л байх юм бол утаа ерөөсөө шийдэгддэггүй юм байна гэдгийг бас ойлгож авлаа. Жишээлбэл сайжруулсан түлш гэж ярихын өмнө болохоор төслийн зуух гээд л ярьсан. Тэгээд л зуух ч байдаг юм уу, түлш ч байдаг юм уу, мэдрэгч ч байдаг юм уу ямар нэгэн байдлаар утаа үйлдвэрлэдэг зүйлд бид нар мөнгө зараад л байх юм бол утаа чинь байгаад л байх юм байна гэдэг тийм зүйл. Тэгэхээр цаашид утаанд мөнгө зарахгүй байа гэдэг бас нэг ийм зарчмын бодол. Тэгээд төр ерөөсөө технологи сонгож сонгож болдоггүй юм байна. Технологийн сонголтыг бол иргэд өөрсдөө хийх ёстой байдаг юм байна. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол нөгөө төр мөнгө зараад байдаг тэгээд

төр технологи санал болгоод байсан байгаа байхгүй юу. Одоо энэ төслийн гоё өлзий зуухыг тавь ч гэдэг юм уу эсвэл энэ шахмал түлшийг түл ч гэдэг юм уу, тэгэнгүүт ерөөсөө энэ асуудал чинь бас шийдэгдэхгүй байна. Энэ чинь бол бас иргэдийн өөрсдийнх нь сонголт. Хамгийн зах зээлийн зарчмаа аль нь илүү үр ашигтай байна гэдэг тэр зүйлийг хийх ёстой гэдэг. Тэгэхээр ийм 3 сургамжийг бол сая сонсголын үр дүнд миний хувьд бол олж авсан. Тэгээд та бүхэндээ бол улс төрийн манлайлал гаргаад ийм шийдэмгий алхам хийх асуудлаар Засгийн газарт бас чиглэл өгөх ийм зүйлийг санаачлаасай гэж уриалах байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Мөнхбат гишүүн санал хэлье .

Ц.Мөнхбат: Манай ажлын хэсгийн дүгнэлтээс үзэхэд бол дээрээс нь Нийслэлийн Засаг даргын зүгээс хэлж байгаагаар бол ирэх намраас эхлээд бас манай энэ утааны түлш өөрчлөгдөхөөс хамаараад, утааны байдал бол эрс гайгүй болох юм байна гэж ойлголоо. Тэр дэд бүтэц татах нөгөө хийн хэрэглээ нэвтрэхэд бол бас нэлээн цаг хугацаа орох байх л даа. Бодвол яаж ч бодсон. Тэгэхээр зэрэг энэ хооронд л бид нар энэ түлшнийхээ чанарыг сайжруулах, сайн түлш түлдэг байх гэдэг энэ зүйл дээр бол илүү их хяналттай л болох шаардлагатай юм байна. Бид нарт өмнө нь бас гайгүй болж байсан ийм кэйс байгаа учраас тэр рүүгээ эргэж дөхөх тал дээр бол нэлээн зоригтой шийдвэрийг л гаргаад явах ёстой юм байна л гэж бодогдож байна.

2 дугаарт нь энэ “Тавантолгой түлш” гээд нэг компани байгаа. Тавантолгойгоос мидлинг авчирдаг. Одоо аягүй бол коксожсон түлш авчрах гэж л байгаа юм байна л даа. Дэлхийн хамгийн өндөр агуулга, илчлэгтэй гээд л манай Монгол Улсыг тэжээж байгаа гээд сайхан нэртэй уурхайн нэрээр нэрлэгдсэн “Тавантолгой түлш” гэдэг компанийг утаагүй түлш гэдэг нэртэй болгомоор байна. Ингэж санал хүргүүлмээр байна. Тэнд ажиллаж байгаа хүмүүс нь ч гэсэн бас энийг ухамсарлаж, үүргээ биелүүлэх хэрэгтэй. Утаагүй түлш гэдэг нэрээр нь Улаанбаатарын утаагүй түлш ч гэдэг юм уу. Ингэж явж бас хаана хаанаа энэ ажил хариуцаж байгаа хүмүүс жоохон хариуцлагатай, ухамсартай байлгах тал дээр нь анхаарах чиглэл өгөх ийм хэрэгцээ шаардлага байна уу гэж бодогдож байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа Батчимэг гишүүн саналаа хэлье.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Жаргалан гишүүнтэй үнэхээр санал бүрэн дүүрэн нийцэж байна. Товчлоод хэдэн санал хэлье. Ер нь бол энэ агаарын бохирдол, утааны хяналтын сонсгол дээр ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсэг бол бас чадах ядахаараа санаачилгатай, цаг хугацаанд нь олон олон зүйлүүдийг амжуулж, хэлэлцүүлэг ард иргэдийн саналыг сонссон маш сайн бас ажлуудыг бол хийж амжсан. Иргэд бол маш их бухимдалтай, шүүмжлэлтэй байгааг бол бүгдээрээ мэдэж байгаа. Арга ч үгүй. Одоо энэ өнгөрсөн хугацаанд 2008 оноос хойш ер нь агаарын бохирдол, утааны асуудлыг маш хүчтэй ярьж, нийслэл болон Засгийн газар улсын төсөв, тэгээд гадаадын олон олон банк, АХБ, тэгээд л буцалтгүй тусламж маш олон хөрөнгө цэвэр агаар сан энэ тэр гээд энэ сая Жаргалан гишүүний хэлснээр ер нь бол бараг 5 их наяд гаруй төгрөгийг ингээд цацчихсан байгаа юм. Тэгээд өнөөдөр утаа буурсан уу. Агаарын бохирдол буурсан уу. Утаа багассан уу гэхээр бол огт үгүй. Бүр ч харин эсрэгээрээ нэмэгдсэн байх. Энд нэг юмыг бүүр онцолж хэлэх гээд байгаа юм. Энд тэр 4 дээр байгаа байх. Тэр Засгийн газарт өгөх чиглэлийн. Хүний амь нас гээд. Тэгээд өнөөдөр энэ Монголын

төр чинь ер нь хүнийхээ амь нас, иргэдийнхээ амьд явах баталгааг ер нь яаж хангаж ажиллаж байгаа юм. Өчнөөн жилийн хувьд сүүлийн 1 жил гэхэд л 700 гаруй иргэд угаартлаа гэж байгаа юм. Тэгээд энэ угаартсан иргэдийн амь насыг өнөөдөр ингээд л зүгээр угаартаад л өнгөрчихлөө. Дүн шинжилгээ хийгээд нотолгоо гэр ахуйн чанартай яасан юм уу, нөгөө тэр юу нь ажиллаагүй юм уу энэ тэр гээд ингээд нэг тиймэрхүү юмаар ингээд хаагаад хүний амь насыг үнэгүйдүүлээд өнгөрөөд л яваад байх юм болов уу даа.

Тэгэхээр би энэ дээр юу гэж хэлэх гэж байгаа гэхээр ерөөсөө энэ хүний амь нас гэдэг юман дээр нөхөн олговор ч юм уу, эсвэл нөхөн төлбөр ч байдаг юм уу, эсвэл тэр хохирлыг барагдуулах ч байдаг юм уу ямар нэгэн байдлаар 16 жил үнэгүйдүүлсэн энэ их төсвийн мөнгийг ингэж зарж үнэгүйдүүлсэн энэ үе үеийн Засаг дарга нар, үе үеийн Засгийн газрын тэргүүнүүдийн энэ байдалд бид нар өнөөдөр анхаарч, энд ямар нэгэн тэр хүний амь насыг өнөөдөр мөнгөөр хэмжихгүй нөхөн төлбөр, нөхөн олговроор хэзээ ч хааж яаж чадахгүй л дээ. Тэгэхээр энэ дээр хууль байхгүй. Тэнд ерөөсөө юу байхгүй гэж яриад байдаг. Энд ямар нэгэн бид нар бодитой юм хийх шаардлагатай гэж би бодож байна. Энэ олон хүний амь насыг яах юм.

Дараа нь ер нь энэ дараа дараагийн сонсголыг энэ Улсын Их Хурлын намрын чуулган эхлэхэд хаврын чуулган эхлэхэд заавал жилдээ 2 удаа тайланг нь сонсдог байх хэрэгтэй байна. Энийг бүр албан ёсоор оруулж өгөөч гэж би хүсэх байна. 2 удаа жилд утаа эхлэхээс өмнө, дараа нь намрын, хаврын чуулган дээр сонсгол тайлан сонсьё гэдгийг энд бүр оруулж өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Үндэсний хороо байгуулагдлаа. Байгаль орчны сайд тэргүүлж байна. Ганц Байгаль орчны сайд энийг тэргүүлээд амжих уу. Түлш гэдэг чинь түлш, утаа, агаарын бохирдол тус тусдаа дандаа өөр өөр юутай. ЭМЯ ч хамаарна, ЭХЯ ч хамаарна. Тийм учраас ер нь цаашдаа Засгийн газрын тэргүүн, бүр арга ядахад Шадар сайд Амарсайхан сайд энэ тэр ер нь энэ ажлыг ахалж ажиллуулах ийм саналыг би оруулж байна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж би санал хэлэхээр нэрээ өгсөн юм. Тэр дагуугаа 2, 3 зүйл байна.

Манай ажлын хэсэг бол бүхий л мэргэжлийн байгууллагуудынхаа мэдээлэл, дүгнэлт дээр тулгуурлаад, хяналтын ерөнхий сонсголоо зохион байгуулаад, тэндээс тов тодорхой дүгнэлт, саналууд гаргаад ирсэн байна. Энэ дээр 2, 3 зүйлийг бид илүүтэй анхаарах ёстой болов уу гэж би бодоод байдаг юм. Энэ агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр олон арга хэмжээнүүд авсан. Үр дүн яав гэдэг асуудал яриад байгаа. Гэтэл бид нэг цэгээс гарч байгаа утаа гэдэг юм уу, хүнд элементүүдийнхээ үзүүлэлтийг бууруулах талаар тодорхой юм хийсэн боловч нэмэгдээд байгаа эх үүсвэр гэдэг юм уу нэгжүүдээ анзаараагүй орхичихсон байхгүй юу. Тэгэхээр энэ 4 уулын дундах энэ хөндий дотор агаар солилцооны ямар багтаамж юу байгаад байгаа юм бэ. Энд ер нь хэдий хэмжээний утаа хий гаргадаг юм байж байж нөгөөдөх дотор нь хангагдаж явах юм бэ гэдэг асуудлаа бид ер нь бага судалсан улс юм билээ шүү дээ. Тэр битгий хэл түлш түлээд утаа гаргахын зэрэгцээ энэ чинь дотоод шаталтын зарчимтай, хөдөлгүүртэй, өчнөөн юмнууд оруулаад ирчихсэн. Тэр хөдөлгүүрүүд өөрсдөө ашиглалтын гэдэг юм уу. Бас зарчмын алдаа элдэв бусын юмнууд гарвал ялгардаг хий бүх юм нь нэмэгдээд явчихдагийг бид амьдралаараа л мэднэ шүү дээ энэ чинь. Дизель

тэрэгнүүдээс авхуулаад өглөө хүйтэн дээрээ асахаар ямар хэмжээний юм ялгаруулдаг билээ, халчихсан хойноо ямар хэмжээний юм ялгардаг билээ гээд. Тэгэхээр зэрэг энэ талаасаа ер нь бас нэг судалгаа юмнуудаа хийж, энэ нөхцөл стандартаа хангуулах талаас нь бид анхаарлаа хандуулах ёстой байх. Үүнийг ер нь бид нэг дуугарах цаг нь болсон болов уу гэж би нэг ийм бодоод байдаг юм.

2 дахь зүйл ерөөсөө л үнэхээрийн л эрүүл аюулгүй орчин бүрдүүлэе. Агаар орчны бохирдлыг бууруулъя л гэж үнэхээрийн л ярьж байгаа бол энергийн хангамжийг нэмэгдүүлэх тухай асуудал байгаа юм. Өнөөдөр бид яг ний нуугүй үнэнийг хэлэхэд цахилгаан дулаан хоёрынх нь хангамж өөрөө тийм хүрэлцээтэй биш байгаа үйл явцаас хамаараад энэ ажил үр дүнтэй явж чадахгүй байгаа байхгүй юу.

2 дугаарт түгээдэг шугам сүлжээний асуудал байгаад байгаа байхгүй юу. Үүнийг иж бүрэн шийдэх тэр 2040 гээд сая хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний юу батлагдчихлаа. Энэ том зарчмаа барьж, бид илүүтэй ажиллах ёстой. Энэ бол бид нарын хамгийн тэргүүн ээлжид бодох хөрөнгө мөнгөө чиглүүлэх ёстой гол зүйл энэ. Үнэхээрийн л хотжилт бий болгоё, тэр нь иргэддээ ээлтэй байя гэвэл бид энэ хүн төрөлхтний бий болгосон энэ төлөвлөлт соёлыг бий болгохоос өөр арга байхгүй. Тийм учраас тэр нэг дэд төвүүд гэж 4, 5 зүйл яригдаад байгаа. Энэ дээрх ажлыг хурдасгах арга хэмжээнүүдийг шуурхай авч, асуудлаа зохицуулах ёстой.

Дараагийн миний нэг хэлчихмээр байгаа санаа бол яах аргагүй түлш л хийгээд л юм түлж байгаа бол утаа ч байна уу, хий ч байна уу, элементүүд ч байна уу ялгарна. Тэр нь хүлээн зөвшөөрөгдөх тухай ойлголт л байгаа. Тэгэхээр тэр хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс бага хэмжээний юм ялгаруулдаг тэр стандартыг нь л баталж өгөх тухай л асуудал байгаа. Түлш дээрээ ч тэр, зуух дээрээ ч тэр, яндан дээрээ ч тэр стандарт, техникийн зохицуулалтыг нь бид баталж өгч байж энэ нэлээн тийм зохистой юм руугаа зөв явах болов уу гэж л би бодоод байгаа юм. Тэгэхээр үүнийг нь нэлээн сайн анхаарч, энэ удаагийн өгөх гол чиглэл энэ тал руугаа, тэр хяналт, мониторингийн чиглэлийн юмнууд байх байх. Би төр хийнэ гэхээсээ илүүтэйгээр тэгдэг боломж нөхцөлүүдийг нь бүрдүүлж өгөөд, тэрийгээ хэрэглэх үйл ажиллагаа нь иргэдийнх нь эрх ашиг байх ёстой. Гэхдээ өнөө хүний эрх нөгөөдүүлийнхээ эрхээр хязгаарлагддаг гэдэг зарчмаа барьж нэгэнт л хотжиж амьдарч байгаа бол бусдынхаа эрхэнд халдчихгүй байх тухай л асуудал шүү дээ.

Тийм учраас энэ чинь нэг стандартыг нэг мөр мөрдүүлэх гээд зүтгээд яваагийн гол утга учир энд л байгаа л даа. Тэгэхээр энэ талаасаа л асуудалдаа бид нэлээн харах ёстой болов уу. Манай энэ дүгнэлттэй нь тулгуурлаад дараагийн хэлэлцэх гэж байгаа энэ шийдвэрийн төслийн үзэл санаа энэ рүүгээ чиглэх болов уу гэсэн ийм л саналтай байна.

Ингээд гишүүд санал хэлж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаас гарч байгаа санал, дүгнэлтийг дэгийн тухай хуулийн 95-д зааснаар ажлын хэсгийн ахлагч маань танилцуулъя. Чуулганы нэгдсэн хуралдаанд. Ингээд өнөөдрийн Байнгын хорооноос тайлан мэдээлэл сонсоод гарч байгаа санал, дүгнэлтийг Чинбүрэн гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.02 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. **Тайлантай холбогдуулаад “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

Мэдээллийг ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн танилцуулна.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Утааны асуудлаар хяналтын сонсгол явуулах талаар цахим системд байршуулсан нийтийн өргөдөл холбогдох хуульд заасан тоонд хүрснийг Монгол Улсын Их Хурал авч хэлэлцсэн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар утааны асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол явуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Мөн хуралдаанаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг 22 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн ахлагч бөгөөд сонсгол даргалагчаар миний бие сонгогдсон.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 7 дугаар тогтоолоор ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр агаарын бохирдлыг бууруулах хүрээнд бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл гэсэн сэдвээр зохион байгуулахаар тогтож тогтоолыг баталсан.

Ингээд ерөнхий хяналтын сонсголыг мөн хугацаанд амжилттай зохион байгуулж, уг сонсголын тайланг бид сая үүний өмнө хэлэлцсэн.

Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн шийдэл сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсантай холбогдуулан Засгийн газарт тодорхой асуудлаар чиглэл өгөх нь зүйтэй гэж ажлын хэсгээс үзсэн учраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна.

Төсөлд угаарын хий мэдрэгчийг гэр хорооллын айл бүхэнд байршуулах, тогтмол ажиллагааг хянах, уг мэдэрч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах, агаарын бохирдлын талаарх мэдээллийг иргэдэд өдөр бүр тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлын өндөр эрсдэлийн эмзэг бүлгийн хүн ам болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс сэргийлэх ажлыг нотолгоонд тулгуурлан эрчимжүүлэх төлөвлөгөөг боловсруулан зорилтот хүн амд хүрч ажиллах, зан үйлийг нь өөрчлөх, эмнэлгийн бэлэн байдлыг ханган ажиллах, угаартаж амь насаа алдсан иргэдийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, шалтгааныг тогтоож, нотолгоонд тулгуурлан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах, ахуйн орчинд угаартсан иргэдэд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг тогтмол тайлагнах, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох зэрэг 13 заалтыг тусгалаа.

Тогтоолын төслийг та бүхэнд хүргэсэн байгаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Ж.Батжаргал: Чинбүрэн гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөл манай Байнгын хорооны гишүүдэд хүргэгдсэн байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Жаргалан гишүүнээр тасаллаа Амгаланбаатар гишүүн асуултаа асууя.

О.Амгаланбаатар: Өмнө нь бас яг иймэрхүү чиглэл, иймэрхүү арга хэмжээ ер нь бас Засгийн газар луу өгч байсан тохиолдол байна уу. Ер нь бол сүүлийн тэгээд л 20 жил утааны асуудал яриад л яриад л түрүүн Жаргалангийн хэлдгээр нэг гал унтраах арга хэмжээ авсан, байсан 2-ын хооронд явсаар байгаад ингээд өнөөдрийн нөхцөл байдал үүсчихсэн. Тэгэхээр ер нь бас нэлээн тийм шийдэмгий арга хэмжээ л авах нь зөв байх даа. Тэгээд одоо ингээд яваад л энэ чинь яваад л, яваад л, замраад л тэгээд л нэг утаа мэдрэгч, эсвэл нэг түлшний сайжруулалт гэж явсаар байгаад л ингээд байдаг. Өнөөдөр чинь дэлхий чинь хаашаа явж байна вэ. Тэгэхээр бид нар энэ технологийн шийдлүүдийг харсан, эсвэл бас арай өөр арга замаар л явахгүй бол өнөөдрийн энэ арга замаар яваад хаашдаа энэ бүтэхгүй.

Тийм учраас ингээд ийм чиглэл өгч байснаас энийгээ эргэж сайн хараад, бүр энэ технологийн шийдлүүдийг харсан, тодорхой хугацаатай 3 жил гэдэг ч юм уу, 2 жил 5 жилийн хугацаанд түрүүний тэр газны асуудал ярьж байна. Одоо энэ цахилгаан станцын асуудал байж байна. Бүр нэг иймэрхүү иж бүрдлээр нь харсан чиглэл байвал яадаг юм бэ. Тэгж болох уу гэж асууя.

Ж.Батжаргал: Хариулъя. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Би бас Байнгын хорооны гишүүддээ баярлаж байна. Ер нь бол энэ утаагүй болчихъё гэсэн ийм 3 жилийн том төлөвлөгөө дээр л ер нь анхаараарай л гэсэн үүрэг өгөөд байна шүү дээ. Тэгэхээр бид ч гэсэндээ бас ер нь Нийслэлээс авхуулаад Монгол Улс даяараа 3 жилийн хугацаанд түүхий нүүрснээсээ салчихсан. 2-т нийслэл нь энэ түгжрэлийн асуудлаа шийдчихсэн. 3-д утаагүй болчихсон байх нь бол бид нарын энэ хууль санаачлагч хууль батлах байгууллагын хувьд бол бас том зорилго байх ёстой. Өмнөх тохиолдол байна. Туршлага байна. Өмнөх туршлагауд бол би өөрөө яг эмийн түр хороог ахалж ажиллаж, мөн Засгийн газарт чиглэл өгсөн, тайлангаа тавих үүрэг өгсөн. Өнгөрсөн намрын чуулганаар би тайланг Байнгын хороон дээрээ сонсох ёстой байсан. Одоог хүртэл тайлангаа өгөөгүй Засгийн газар явж л байна. Тийм учраас бид ер нь энэ парламент өөрөө энэ хянан шалгах тогтолцоогоо илүү хүчтэй болгож, өөрт байгаа энэ зүйлээ ажил болгож л байхгүй бол ялангуяа Байнгын хороо ахалж байгаа дарга нар энэ дээр онцгой анхаарахгүй бол яадаг юм яадаг юм, ингээд явж байг гэдэг ийм юм үүсчих вий.

Тэгээд нөгөө том улс төрийн манлайлал байхгүй болчихоод энэ ажлууд нь хийгдэхгүй байгаад 3 жил өнгөрөх юм бол бид энд суугаад юугаа хийх вэ дээ. Яг ийм тохиолдол гарсан учраас би бас энэ дээр бүр хариуцлагатайгаар бас хэдүүлээ энэ дээр нэхдэг, шаарддаг, тайланг нь тавиулдаг. Тэр ч утгаараа бид нарын гол хүсээд байгаа зүйл бол энэ дэд хороо байгуулж, байнгын үйл ажиллагаатай, энэ 3 жилийн хугацаанд утааг бууруулах зорилготой дэд хороогоо байгуулъя. Үүний хуулийг гаргалгааг нь Байнгын хороогоороо, гишүүдээрээ бүгд бүгдээрээ нийлж байгаад энийг батлуулъя. Нэмэлт, өөрчлөлт гаргаад, тэгээд дэд хороо байгуулах эрхээ аваад, дэд хороогоо байгуулаад, тэгээд хавар, намрын чуулган бүр дээр хийж байгаа ажил, хийх гэж байгаа ажил, утааг бууруулах зорилго, ажлуудыг нь

байнга сануулдаг, байнга тайлан авдаг ийм хяналтын тогтолцоог ажиллуулъя. Тэгэхээр энэ дээр бас та бүхнийг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

Ж.Батжаргал: Амгаланбаатар гишүүн тодруулъя.

О.Амгаланбаатар: Би бол яах вэ энэ утааны чиглэлээр гэж асуусан юм Чинбүрэн гишүүн ээ. Гэхдээ бид нарын хувьд байна шүү дээ яг тодорхой тэдэн жилийн дараа 1 ч яндангүй болно гэдэг ийм зорилт тавьж болох уу. 1 ч утаа гаргах тийм яндангүй болъё. Тэгээд түүндээ хүрэхийн тулд яг 3 жилийн дараа 1 ч яндангүй болно шүү гэдэг ийм л чиглэл өгмөөр байна л даа. Тэгэхийн тулд түүнтэй холбогдох ямар зардал гарах юм. Тэрийгээ гаргаж ир гэдэг. Түүнээс одоо ингээд хэдүүлээ яг энэ саяын таны хэлдэг шиг ингээд л өгдөг, Засгийн газар аргацаадаг, ингэж явсаар байгаад л 30 жил болчихсон байхгүй юу. Тэгэхээр яг ийм хэмжих боломж, та түрүүн бас нэг хэмжих боломжтой гэж яриад байна лээ. Тэгэхээр хэмжих боломжтой юм чинь 1 ч яндангүй болгох, 1 ч утаа гаргадаггүй болох, эсвэл 1 ч тэр модон жорлонгүй болох, эсвэл гэрээс гэрийн хооронд гэдэг юм уу Улаанбаатарын 1 захаас нөгөө зах хүртэл 30 минутад очдог болох гэдэг ч юм уу ийм тодорхой үр дүнтэй л юмнууд байвал их зүгээр гэж ингэж бодож байна. Та энэ тал дээр юу гэж бодож байна.

Ж.Батжаргал: Хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр бид нарын бас энэ тайлан дотор дүгнэлт дотор орсон мөн сонсголд оролцсон аж ахуйн нэгжүүд шийдэл яригч хүмүүстэй уулзаад ярихад бас Батжаргал гишүүн түрүүн хэллээ. Жаргалан гишүүн бас бас хэллээ. Ерөөсөө хувийн хэвшлийг энэ утаа бууруулах үйлсэд оролцуулах явдал юм. Бид стандартаа л тавиад өгчихье л дөө. Төр шахдагаа больчихье л доо. Харин тэр стандартыг хангаж чадаж байгаа зуух нь, технологи нь, иргэн өөрөө сонгох, айл өрх өөрөө сонгох боломжийг нь олгоё. Жишээлэх юм бол бид Монгол хүн чинь бас гэртээ гал түлэхийг хүснэ шүү дээ. Тэгэхээр бид бүр яндангүй болчихно гэвэл бас худлаа.

Харин тэр яндангаас гарч байгаа утаа бусдыг хордуулдаггүй л байх ёстой. Тэр л шаардлагыг тавьдаг ийм тогтолцоог хийх ёстой. Тийм учраас ер нь бол энэ том иж бүрэн тогтолцооны бас нэг том зорилго нь ерөөсөө би Жаргалан гишүүнтэй санал нэг байна. Утаа гаргадаг технологийг муу утаа гаргадаг технологийг санхүүжүүлэхээ л больчихье. Тэгээд дэд хороо .../минут дуусав/

Ж.Батжаргал: Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Тэгэхээр ажлын хэсэгт талархаж байна. Ямар нэгэн байдлаар гал түлж л байгаа бол утаа гарна. Тэгэхээр утааг тодорхой хэмжээнд бууруулах үр дүнтэй арга бол энэ халаалтын янз бүрийн технологиуд л байгаа. Тэгэхээр үүнийгээ хэрэглэх гэхээр өнөө дулааны эх үүсвэр аймгуудад ялангуяа хангалт муутай байгаа. Нөгөө талаар цахилгаан эрчим хүчний үнэ тариф өндөр байгаа. Тийм учраас эхнээсээ халаалт, тоног төхөөрөмж хэрэглэж байгаа айлууд чинь буцаад зуухаа оруулах хэмжээнд л очиж байна л даа. Тэгэхээр нөгөө хүмүүсийн орлого юмтай бол таарч өгөхгүй, уялдаж өгөхгүй ийм байдал бий болоод байгаа юм. Тийм учраас энэ тогтоол дээр энэ чиглэлээр халаадаг тоног төхөөрөмжүүдийг өргөн хэрэглэх тал дээр нь ямар чиглэл Засгийн газарт өгөх юм.

Дулааны эх үүсвэрүүд дулааны станцуудыг аймгуудад болон дүүргүүд нэмэгдүүлэх чиглэлээр энэ Засгийн газарт чиглэл энэ дотор байгаа юм уу, үгүй юм уу. Тэр нөгөө халаагч хэрэгслүүдийн үнийг тодорхой хэмжээнд бууруулах, хөнгөлөлттэй ногоон зээлд хамруулах асуудлуудыг бас эндээ тусгаж өгөх нь зүйтэй биш үү гэсэн ийм зүйлийг асууя. Энэ дотор орж, багтаж байгаа юу, үгүй юу. Тэгээд ер нь энэ өгч байгаа энэ тогтоолынхоо хэрэгжилтийг намрын ээлжит чуулганы эхний 7 хоногт гээд хугацааны хувьд бас их ойрхон юм. Нэг бол дотор нь 2 хуваагаад богино хугацаанд хэрэгжүүлэх ажил гээд. Дараа нь урт хугацаандаа тэр томоохон хийн халаагч мөн цахилгааны эх үүсвэр хийх гэх мэтчилэн бусад асуудлуудаа урт хугацаанд нь гээд тусад нь бас заалт болгоод ялгаад өгвөл зохимжтой биш үү. Тэгээд яг энэ тогтоолыг харвал нэг их үр дүнд хүрчихмээр хэдхэн сарын хугацаатай хэрэгжээд ингэсэн л нэг юм. Тэгээд 1 тайлан хэрэгжилт өгсөн болоод дуусмаар юм шиг ийм үр дүн багатай тогтоол л харагдаад байгаа юм.

Бас 2 дахь асуудал нь тэр агаар бохирдуулаад байгаа уул уурхайн компаниудыг тэр дэргэдэх сумынхаа агаарын бохирдлыг бууруулахад бас тодорхой төлөвлөгөө төсөв гаргаж ажиллах чиглэл өгвөл яадаг юм. Ялангуяа энэ төрийн өмчтэй том аж ахуйн нэгжүүд байна. Тэгээд тодорхой тэр сумд нь агаарын бохирдлыг бууруулах тодорхой ажлуудыг хийх, сумыг нүүлгэн шилжүүлэх байдаг юм уу энэ чиглэлийн үүрэг чиглэл өгөхгүй бол бид түрүүн ярьж байсан Цогтцэций сумын хувьд хүн амьдрах арга байхгүй л ийм л байдалтай байгаа юм. Ийм 2 асуулт, санал байна.

Ж.Батжаргал: Асуулт, саналд хариулж тайлбар өгөх үү. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Саналыг хүлээж авч байгаа. Бид бас ажлын хэсгийн гишүүд маань өчигдөр бид энэ дүгнэлт, Засгийн газарт өгч байгаа чиглэлээр ярихад бас энэ намрын чуулганы эхний 2 7 хоногт багтаад тайланг сонсьё гэдэг санал бас хэлсэн. Тэгэхээр энийг бид бас тайлан тавь гэдгээ бүр яг энэ тогтоолдоо оруулж өгье. Тэгээд тогтоолдоо оруулаад, хөшүүргийн хувьд бол ер нь яндан буулгасных нь давуу талд нь бас энэ хөшүүрэг бий болгох замаар янданг буулгах гээд энэ өгүүлбэр оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ сонсгол маань эрчим хүчний үнэ нэмэгдэхээсээ өмнө хийгдсэн. Тэгээд харамсалтай нь дараа нь бас таны хэлж байгаа үнэн. Тариф, үнэ нэмэгдээд, нөгөө цахилгаанаар халаагаарай, яндангаа буулгаарай гэсэн том бодлого маань байхгүй болоод, буцаад эрчим хүч их үнэтэй болсон. Халаалтаа цахилгаанаар шийдэх боломж хязгаарлагдчихсан, асар их үнэтэй болсон энэ байдал бол өөрөө янданг буулгах биш харин нэмэх ийм нөхцөл бүрдсэн. Энэ эрчим хүч мэдээж бас үнэ нэмэх нь бол өөрөө аргагүй эрчим хүчний нөгөө бие даасан байдлыг алдагдуулж байгаа. Цаашид оршин тогтнох байдлыг хүртэл хөндөж байгаа учраас нэмэх болно. Гэхдээ нэмэхдээ ямар ямар зүйлүүд дээр бид татаас өгч, ямар сайн зүйлийг дэмжих вэ гэдэг бодлогыг Засгийн газар гаргаж, энэ намраас өмнө оруулж ирэхгүй бол болохгүй гэдэгтэй тантай санал нэг байна.

Тэгэхээр бид ерөөсөө л миний давтаж хэлээд байгаа зүйл бол дэд хороо үнэхээр мөн чухал шүү. Дэд хороог л дэмжиж хэдүүлээ байгуулж чадвал хүний эрхийн дэд хороотой адилхан байнгын үйл ажиллагаатай, тэгээд Агаар бохирдлын үндэсний хороотой байнга уялдаж ажиллах ийм бүтэц энэ Их Хурал дээр байж байж л бид энэ ажлыг сайжруулах юм байна лээ. Тэгээд энэ чинь ганцхан байгаль орчин, уур амьсгалтай тэмцэх асуудал биш. Энэ чинь дээр нь ЭХЯ, Эрдэс

баялгийн яам гээд л бүгд л орчих гээд хамааралтай учраас бид дэд хороогоороо л ажлаа хийх нь илүү үр дүнтэй болох юм байна шүү гэдгийг гишүүддээ бас дахин сануулж хэлье.

Ж.Батжаргал: Баярлалаа. Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ ажлын хэсэгт орж ажилласан. Нэлээд үйл ажиллагаа зохион байгуулсан. Гэхдээ энэ Засгийн газарт өгч байгаа чиглэл дээр хэдэн санал байна л даа. Сая Чинбүрэн гишүүн ярилаа. 2017 онд төчнөөн сая доллароор ингээд ТЭЗҮ хийгдсэн байна. Энэ ажил яагаад орхигдсон тал дээр ер нь Засгийн газарт үүрэг болгож энэ тогтоол дээр оруулж өгнө үү гэж.

2 дугаарт бол үйлдвэрлэж байгаа түлш дээр хяналт тавимаар байна шүү дээ. Айл болгонд нөгөө хянадаг юу байршуулна гээд байна. Тэгээд байршууллаа гээд яах юм. Тэр нь стандарт бус байна. Ингээд угаар ихсээд утаа бол ихсээд байна гээд үр дүн гарлаа гэхэд тэр дээр тэр айл бүрд хийсэн юугаар биш яг эхний түлш үйлдвэрлэж байгаа үйлдвэрийн газарт бол хяналт тавимаар байна. Тэр дээр стандартын дагуу түлш үйлдвэрлээд, хэрвээ ямар нэг юугаар стандарт бус юм хийгээд л асуудал үүсгэх юм бол хариуцлага тооцно гэдгийг хатуу мэдэгдэх хэрэгтэй.

Тэгээд гэр хорооллыг өнгөрсөн он жилүүдэд хэчнээн тэрбум төгрөг утааг бууруулахын төлөө зарсан байна. Хэрвээ тэр мөнгөөрөө, одоо зарцуулах гээд байгаа мөнгөөрөө бид нар гэр хорооллыг стандартын байр байшинтай ард түмнийг хангах чиглэлээр тэгээд яваандаа газ цахилгаан халаалт өгөөд, яндангүй хороолол бий болгох тал дээр анхааран ажиллана уу гээд Засгийн газарт бас чиглэл өгөх нь зүйтэй гэж бодож байна.

Одоо Үндэсний хороо гээд Байгаль орчны яамны сайд удирдуулаад л яваад байгаа шүү дээ. Энд нэг яам тэрийг удирдаж, үр дүнд хүрнэ гэж би бодохгүй байна. Сая Батчимэг гишүүний ярьж байгаа нь үнэн. Энийг нэг бол Ерөнхий сайд, нэг бол Шадар сайд удирдаад л энийг үр дүнд хүргэх ёстой. Яагаад гэвэл эрчим хүчтэй холбоотой ихэнх асуудал ЭХЯ-д үүсээд байна шүү дээ.

Тэгээд Чинбүрэн гишүүний яриад байгаа дэд хороо байгуулаад, энэ ажлыг юу ч гэсэн эцэс хүртэл яваад үр дүнд хүргэмээр байна гээд байгаа. Тэр саналыг нь би бас дэмжиж байна. Одоо Их Хурлаас дэд хороо байгуулагдаад энэ ажлыг дахиж шинэ түвшинд хүргэх ёстой. Тэгээд эцэс сүүлд хэлэхэд хагас жилээр ч юм уу, улирлаар юм уу, Засгийн газар ямар үйл ажиллагаа хийж байна. Ямар үр дүнд хүрч байна. Ямар өгөөжтэй байна. Ард түмэнд энэ бүгдийг нь сонсголоор сонсож, дүгнэлт хийж байх нь зөв гээд.

Ж.Батжаргал: Баярлалаа. Саналууд байна. Санал дүгнэлт ярих үеэр хэдүүлээ дахиж ярья. Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Би түрүүн хэлсэн. Агаарын тухай хууль анх 1995 онд батлагдаад, тэгээд 2010 онд бас шинэчилсэн найруулга батлагдсан байдаг. Агаарын тухай хуульд бол бас маш тодорхой заалтууд орсон байдаг юм байна лээ. Тухайлах юм бол 6.1.4-д агаарын бохирдолтой тэмцэх ажлыг Засгийн газар зохион байгуулна. Тэгээд Засгийн газар жил бүр Улсын Их Хуралд энэ ажлаа

тайлагнана гээд заачихсан байгаад байгаа юм. Тэгээд Засгийн газрыг бол миний ойлгож байгаагаар Ерөнхий сайд төлөөлнө. Тэгээд Ерөнхий сайд бол Их Хуралд жил тутам энэ хуулийнхаа дагуу ажлаа тайлагнах ёстой гэж хараад байгаа юм. Тэгэхээр 1 асуулт байна. Яг энэ Байнгын хорооны энэ ажлын албанаас л асуумаар байгаад байгаа юм. Энэ Агаарын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан ер нь гарч байсан юм болов уу. Энэ тал дээр бас мэдээлэл цуглуулж өгөөч. Тэгээд ер нь энэ Засгийн газар, Ерөнхий сайд жил тутам Улсын Их Хуралд ажлаа яг энэ хүрээнд тайлагнасан явдал байгаа юм болов уу. Тэгээд бид нар бол яг энэ гаргах гээд байгаа шийдвэрээрээ энэ тайлагналыг бас хүсмээр байгаад байгаа юм. Яагаад гэхээр аль 2010 онд батлагдчихсан Агаарын тухай хуулиар тодорхой зорилтуудыг дэвшүүлчихсэн. Тэгээд тэр хүрээнд ямар ажлууд бас үе үеийн Засгийн газрууд хийгдэж байсан гэдэг асуудал.

Түрүүн Амгаланбаатар гишүүний асуудаг Улсын Их Хурлаас гарсан тогтоол, шийдвэр ямар юм байдаг юм бэ гэдэг дээр бол хамгийн сүүлд 2010 оны 1 сарын 5-нд Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай гэсэн 02 тоот Улсын Их Хурлын тогтоол батлагдсан байдаг юм байна. Энэ тогтоолын хүрээнд тухайн үед бол Ерөнхий сайд Хүрэлсүх ажиллаж байсан. Тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд бол энэ түүхий түлшийг хотод түлэхийг хориглосон шийдвэрүүд гараад, бас ингээд нэг ийм дорвитой ажлууд хийгдээд явсан гэж харж байгаа. Тэгэхээр энэ удаад бид бол ахиад 6, 7 жилийн дараа тогтоол батлах гэж байна. Тэгэхээр маш тийм дорвитой реформын шинж чанартай ажлуудыг бас санал болгох нь зөв гээд би бас хувьдаа нэг ийм тогтоолын төсөл бэлдээд оруулаад ирчихсэн байж байгаа юм.

Тэгээд Чинбүрэн гишүүний энэ дэд хороо байгуулах санаачилгыг бол бүрэн дэмжиж байгаа. Мөн сая нийтийн сонсголын үеэр энэ Хянан шалгах түр хороо буюу манайхны яриад байгаа энэ хариуцлага хаана яаж тооцогдох юм бэ гээд өнгөрсөн хугацаанд хийгдсэн зарцуулалтууд, тэр бүх зүйлтэй холбоотой зүйлийг Хянан шалгах түр хороо байгуулах гарын үсгийг бол Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний бланк дээр цуглуулаад, тэгээд хуулийн шаардлагад бол гарын үсгийн тоо нийцчихсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ санаачилга бол бас давхар явж байгаа юм. Тэгэхээр бол хэд хэдэн санаачилгууд яваад байна л даа. Тэгэхээр бид нар 1 дүгээрт энэ Хянан шалгах түр хороогоо байгуулъя. Дэд хороо байгуулах ийм дунд хугацааныхаа бас бүтцийг байгуулъя. Тэгээд Засгийн газарт ийм дорвитой үүрэг чиглэл өгье гэдэг ийм 3 чиглэлээр ажиллах боломжтой гэж хараад байгаа. Тэгээд дараа нь санал дээрээ бас нөгөө тогтоолын төсөлд оруулах саналаа хэлье.

Ж.Батжаргал: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Агаарын тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн дүгнэлт их чухал зүйл юм байна лээ. Тэгээд бидэнд яг тийм мэргэжлийн байгууллагаар яг Агаарын тухай хуультай холбоотой, хэрэгжилттэй холбоотой зүйлүүд Аудитын газраас хэд хэдэн удаа дүгнэлтүүд өгсөн байгаа. Харамсалтай нь тэр зөвлөмжийг биелүүлдэг зүйл байхгүй. Биелүүлээгүйн төлөө хариуцлага тооцдог ажил байхгүй. Тэгээд л ерөөсөө ингээд л ярьсаар байгаад л дуусдаг. Та бүгдийн хэлж байгаа яг үнэн. Бид ингээд л ярьсаар байгаад л хэчнээн жил өнгөрчихсэн. Тийм учраас жоохон Их Хурал өөрөө хариуцлагаа тооцох, хяналтыг тавьдаг, хариуцлага нэхдэг ийм механизмаа л бид сайжруулахгүй л бол энэ ажил биеллээ олохгүй юм байна лээ. Тэгээд үүнийг хийх чухал зүйл бол дэд хороогоороо л тэр мэргэжлийн байгууллагуудыг нь дуудаад, авчраад тайланг нь

сонсоод, хийгээгүй ажлыг нь нэхээд, шаардаад ингээд л явахгүй бол тэгээд л энэ дундаа өнгөрөөд, тэгээд л өвөл болохоор ахиад л яриад, тэгээд л бухимдацгаагаад л ийм л байдал үүснэ. Тийм учраас хэдүүлээ их тийм дорвитой, шийдэмгий ажил хийнэ гэх л юм бол бид дэд хороогүй л бол бүтэхгүй юм байна гэсэн миний итгэл үнэмшил шүү. Тэгээд зөндөө аудитын тайлангууд байна. Дүгнэлтүүд байна, зөвлөмжүүд байна. Тэгээд гарч байгаа, хэрэгжсэн зүйлүүдийг нь хараарай. Байхгүй л байгаад байгаа юм. Ийм л зүйл хэлье дээ.

Ж.Батжаргал: Ийм нэг зүйл байгаад байгаа юм. Энэ орчны хийгээд агаарын бохирдлын асуудал төрийн байгууллагуудаас хол яваагүй л дээ. Энэ чинь угаасаа нүдэн дээр ил гараад, зовлонтойгоо нүүр учирдаг ийм л зүйл юм чинь. Тийм учраас Байнгын хороогоор бол энэ асуудал өмнөх 4 жилд ч нэлээн олон яригдсан. Энд нэг зүйлийг хэдүүлээ ялгаж ойлгох ёстой. Түлш үйлдвэрлэх гэдэг юм уу, түлшний эцсийн бүтээгдэхүүн байх тэр стандартыг бид баталчихсан. Тэрийгээ хүлээн зөвшөөрөгдөх үзүүлэлтүүдийнхээ байж болох доод хэмжээ рүү нь оруулж ирж батлах ёстой байтал зүй нь гэтэл хийж байгаа түлшиндээ тааруулаад стандарт баталчихсан. Тэгэхээр хэн нэгэнд буруу өгөх янз байхгүй.

2 дахь зүйл. Та хэд мэддэг дээ. Одоо манай энэ эсгийг орон нутгууд хийсэн. Тэгэхээр зэрэг Монгол гэрт яваад орохоор нэг тийм зарим тохиолдолд зунгаг үнэртээд байдаг. Угаах шат дамжлагыг нь орхигдуулж эсгий хийцгээсэн. Яг тэрэнтэй адил энэ түлшийг хийхдээ бид хатаах дамжлагыг нь орхигдуулсан байхгүй юу даа. Тэгээд урин дулааны цагт хийгдсэн түлш болохоор зэрэг хаталтаа гүйцэд авчхаад, ид өндөр ачааллын үед, хүйтний нөхцөлд хийгдчихсэн түлшнүүд түрүүний Чинбүрэн гишүүний хэлдгээр бутарч унадаг хэлбэрээрээ гарч ирээд ингээд болж өгөхгүй, тэр нь эргээд энэ асуудалдаа нөлөө үзүүлээд байсан юм бий.

Тийм учраас ер нь бол урт хугацаандаа бид нар энэ энергийн хангалт, түүнийг дамжуулдаг шугам сүлжээнийхээ асуудлыг бүрэн шийдэж, энэ хот гэдэг ерөнхий төрх рүүгээ орох ёстой. Үүнээс бол бид ухрах ямар ч боломж байхгүй. Харин энийг 3 жилд гэнэ үү, хэдэн жилд хийж дуусгая гэдэг том зорилтоо тавьж, хөрөнгө мөнгө, нөөц боломжоо энэ рүүгээ чиглүүлэх ёстой. Тэр дэд төвүүдийг илүү олноор нь байгуулах ёстой энэ тал руугаа явах ёстой.

2 дахь зүйл. Иргэдэд янз бүрийн мэдээлэл өгөөд байх вий та минь. Түлшний хэрэглээнд өөрчлөлт оруулах гээд байгаа юм. Хатуу түлшнээсээ татгалзаад шингэн түлш ч гэдэг юм уу, хийн түлш ч гэдэг юм уу юм ярьж болж байна. Тэгэхээр өрх гэрийн түвшинд энийг шийдэж боломгүй. Эрсдэл улам нэмэгдэнэ. Өнөөдөр наад зөөврийн маягтай гэдэг юм уу, ахуйн хэрэглээний маягтай газнаас чинь болж олон айл бас орон байргүй болцгоогоод байна шүү дээ. Тэгэхээр энэ том хотод айл болгон өөр дээрээ энэ хийн түлшний юутай байгаад байх юм бол болохгүй. Үүнийг дэд төвөөр нь дамжуулж, нэгдсэн шугам сүлжээ, тэр дээр битүүмжлэл, алдагдалгүй байдал энэ бүх юмнуудыг нь шийдэхгүйгээр бид энэ аюулыг бууруулж чадахгүй. Тийм учраас энэ дээр их бодлогын зөв алхам, тэр дэлхийн улс орнуудын хэрэглээнд нэвтрүүлсэн стандарт юмнуудыг барихаас өөр арга байхгүй. Би бол ингэж бодоод байдаг юм. Энэ талаасаа харъя.

Батчимэг гишүүн асуултаа асууя. Батчимэг гишүүний микрофоныг өгөөрэй.

П.Батчимэг: Би бас түрүүн ярьж байсан санал дээр. Энэ Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийн 4 дээр байгаа. Тэр угаартаж амь насаа алдсан

иргэдийн талаар. Энд яг өнөөдөр бид нар тодорхой оруулж өгмөөр байна л даа. Энийгээ бүүр тодорхой болгож өгмөөр байна гэдэг нэг санал байгаа юм. Энийг яаж ер нь Чинбүрэн гишүүн ажлын хэсгийг ахалсан хүний хувьд яг энэ тогтоолыг хүргүүлэх явцад энэ 4 дүгээр заалт дээр та яг ямар юу эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар ямар заалт оруулж өгмөөр байна гэдгийг 1 дүгээрт асуумаар байна. Энийг нэг тодорхой болгож өгөөч.

2 дугаарт ер нь энэ үндэсний хороо нийслэл дээр байгуулагдсан. Сүүлийн үед ингээд ажиглаад байхаар Засгийн газар, Улсын Их Хурал дээр ямар нэгэн ажлын хэсэг байгуулагдвал тэнд Засгийн газар дээр бас нэг ийм ажлын хэсэг давхардаад байгуулчихдаг. Тэгээд хоорондоо уялдаа холбоо маш муутай байгаа нь бүр сүүлийн үед мэдэгдээд байна л даа. Тэгэхээр энэ саяын байгуулагдсан Байгаль орчин, уур амьсгалын сайдаар ахлуулж байгаа Үндэсний хороог өнөөдрийн манай Байнгын хорооны гишүүд анхаарч үзээсэй. Энэ Үндэсний хороог ер нь Засгийн газрын тэргүүн Ерөнхий сайд эсвэл Шадар сайдаар ахлуулбал ямар вэ гэдэг ийм саналыг би бас хүргэж байна л даа. Яагаад гэвэл ганцхан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд ахлахаар явцуу юм шиг харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ олон яамнууд энэ агаарын бохирдол, утааны асуудал дээр хамт нэг чиг үүргээр оролцох ёстой. Тэгэхээр Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд тэгж байж Үндэсний хороо бүрэн утгаараа ажиллаж байж Их Хурал дээр намрын чуулган, хаврын чуулган дээр тайлан тавих ёстой гэж ойлгогдож байгаа. Энэ дээр ямар бас бодол байгаа бол.

Ер нь Улаанбаатар хотыг нийслэлийг хатуу түлшнээс гаргах асуудлыг ер нь цаашдаа хэрхэн яаж шийдэх арга гарц байна уу. Ийм асуултад хариулт өгөөч.

Ж.Батжаргал: Үндэсний хороог хэнээр ахлуулах барих энэ тэрийг нь Засгийн газарт өгч байгаа шийдвэр юмандаа хэдүүлээ тусгаж болох байх. Тэгэхдээ энэ Үндэсний хороо гэдэг бол нэг салбарын үйл явц биш байхгүй юу. Салбар хоорондын зохицуулалт хангаж байгаа хороо юм. Тийм учраас дотор нь бүх бүрэлдэхүүнүүд ороод ирж байгаа. Тэндээ асуудлаа ярина. Нэгэнт энэ Засгийн газрын түвшинд Үндэсний хороог нь байгуулаад өгч байгаа учраас асуудал байвал тэр Засгийн газрын хуралдаан дээрээ асуудлаа ярьж шийдүүлэх боломж нь бас хангагдах ёстой. Тэгээд энэ том хороонуудыг ажил ихтэй олон юм боддог хүмүүст аваачиж наах юм бол ёстой бүр сарниж мэднэ шүү. Тийм учраас яг асуудлаа барьж байгаа хүн нь бариад яваад байх юм бол магад ч үгүй зөв байхыг үгүйсгэхгүй. Салбар хоорондын зохицуулалтаа хангах гээд бусад салбаруудынхаа юуг хангаад ажиллаад байгаа учраас энэ ажлын ачаалал зовлон гэдэг юм бол бас байдаг. Би мэднэ. Чинбүрэн гишүүн гүйцээж хариулъя.

Ж.Чибүрэн: Би бас гишүүддээ түрүүн Замиран гишүүн ч гэсэн хэллээ. Ер нь Үндэсний хорооны асуудлыг бол Ерөнхий сайд манлайлах нь зөв. Өнөөдөр хагас сайн өдөр болгон шуурхай хийж байна. Ерөнхий сайд өөрөө ахлаад, тэгээд холбогдох сайдууд нь, нийслэл удирдлага тэр чигээрээ оролцоод утааны асуудлаасаа бид энэ хэлэлцүүлэг хийсэнтэй холбоотой бас 7 хоног бүр хуралдаж байна шүү дээ. Тэгэхээр ингээд хуралдаж болж байгаа. Батжаргал гишүүн таны хэлдэг яг тэр. Олон салбар хамарсан асуудал учраас зангидаж ажиллахад Ерөнхий сайдын манлайлал чухал л гэж харж байна. Харин нарийн бичгийн даргаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нь өөрөө ажиллаад, тэнд ёстой жинхэнэ ажлаа хийгээд, тэр тэрэнд тийм үүрэг өгөөд ингэж ажиллаасай гээд ажиллаж байвал яг л Хүрэлсүх Ерөнхийлөгчийн Ерөнхий сайд байх үеийн

өөрөө бүр тэр өдөр шөнөгүй ажиллаад, тэр нөгөө утааны тоо, мэдээлэл аваад л ажиллаж байсантай яг адилхан. Ингээд л ажиллаасай л гэж би бас хүсэж байгаа. Тэгээд тийм боломж байсан. Тийм байдал утаагүй байж чадсан. Тийм утгаараа ингээд ажиллавал илүү зөв байх. Тэгээд энийгээ хэдүүлээ бас Засгийн газарт чиглэл өгөх тогтоолдоо бас оруулчихвал зүгээр юм болов уу л гэж би бас дотроо бодож байна.

Хамгийн хэцүү асуултыг асуулаа. Тэр нөхөн олговрын асуудал. Яг сонсголын үеэр бол олон төрийн бус байгууллагууд энэ угаартаж нас барсан иргэдийн асуудлыг хөндөж ярьж, та бүхэн санаж байгаа бол бүр бид чинь МҮОНРТ-ээр нийтдээ 6 өдөр дараалан дамжуулсан шүү дээ. 2 өдрийн сонсгол биш. Дэд хэлэлцүүлгүүдээ хүртэл шууд дамжуулсан. Үүнтэй холбоотой иргэдийн төлөөлөл зааланд орж ирж ямар байдал үүсгэж байсныг та бүхэн санаж байгаа байх. Бид нөгөө угаартаж эндсэн иргэдийнхээ нөхцөл байдал, юу болсон гэдгийг бас их сайн судалж үзэх хэрэгтэй юм байна. Нотолгоонуудыг нь шүүх шинжилгээний газруудтайгаа хамтарч ямар нөхцөл байдлаас болж ийм нөхцөлүүд үүссэн бэ гэдгийг бас нэг тийм задаргаа хэрэгтэй байна. Түрүүн бас хэлж байна. Түр хороо байгуулах асуудлыг ч хүртэл ярьж байна. Тэгэхээр түр хороо илүү их нотлох баримтууд цуглуулж, мэдээлэлд орох боломж нь илүү шүү дээ. Бид ерөнхий хяналтын сонсгол бол маньд нь мэдээлэл бүр тэр нарийн мэдээлэл рүү орох боломж хязгаарлагдмал, цаг хугацааны хувьд өөрөө боломжгүй байсан. Тэгэхээр нотлох баримт илүү сайн цуглуулж чадах юм бол яагаад яагаад эндсэн бэ гэдгийг бас тодорхой гаргаад, дүн шинжилгээ хийгээд, үүнээс урьдчилан сэргийлэх асуудал нэг номер.

2-т өөрсдийн буруутай, буруугүй гэдгийг бас нотлох нь маш чухал болчихоод байгаа байхгүй юу. Дээрээс нь хариуцлагыг нь хэн хүлээх вэ гэдэг асуудал болчихоод байгаа юм. Нөгөө түлш үйлдвэрлэсэн газар уу, Засгийн газар уу, хэн бэ. Тэгэхээр ерөөсөө Монголд нэг иргэний амь насыг хэдээр үнэлэх вэ гэдэг тоо ч байхгүй юм байна лээ шүү дээ. Үнэлэмж хэд юм .../минут дуусав/

Ж.Батжаргал: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Чинбүрэн гишүүн бас асуултад хариулахыг оролдлоо. Гэхдээ хүний амь нас гэдэг юмыг хэзээ ч мөнгө төгрөгөөр үнэлж, тэрүүгээр хэмжихгүй л дээ. Ядахад энэ утаанд угаартаж байгаа ард иргэдийн тоо 700 гарчихсан. Сүүлийн 1 жилд. Хүний амь нас, энд ядаж оршуулгын зардал хүртэл тавьж өгөх ёстой байхгүй юу даа. Тэр нөхөн төлбөр, нөхөн олговор ямар ч юу байдаг юм. Гэхдээ ямар нэгэн байдлаар л тэр үлдсэн ар гэр бүл, үр хүүхэд, хэн байдаг юм энэ хүмүүст нь тодорхой хэмжээний хохирлыг барагдуулах урагш алхсан нэг арга хэмжээ өнөөдөр бас чиглэлдээ оруулж өгмөөр байна л даа. Эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар бид оролдох ёстой. Дараагийн асуудал .../минут дуусав/

Ж.Батжаргал: Асуултаа гүйцээгээд асуучих.

П.Батчимэг: Бид хүний амь нас гэдэг юман дээр энэ өнөөдөр манай Байнгын хорооны гишүүд үнэхээр тогтож нэг дахиж бүгдээрээ ярилцаж, энэ саналыг бас тусгаж өгөөч гэж би хэлэх гээд байгаа юм.

Дараагийн асуудал нь бид цаашдаа ер нь энэ угаартах асуудлыг ингээд л нотолгоо шаардаад л дүн бүрд шинжилгээ хийнэ гээд л ингээд яваад ийм аргаар

бид энэ асуудлыг шийдэх юм уу. Үндэсний хороо дээр дахиад л ярья. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам сая бас Чинбүрэн гишүүн хэллээ. Санал нэг байна. Үнэхээр баярлалаа. Яагаад гэвэл Үндэсний хороог өнөөдөр бид Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайдаар ахлуулах л энэ саналыг оруулж байна. Энийг бас энэ чиглэлд оруулж өгөөч ээ гээд.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тодруулж хариулах зүйл байна уу. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр бас Батчимэг гишүүнд баярлалаа. Ер нь энэ хүний амь нас гэж яаж хэмжих вэ дээ. Зүгээр нөхөн олговор олговол хэмжээтэй тоо л өгч таарна шүү дээ. Мөнгө өгөх гэж байгаа учраас. Тэгэхээр би тэр тухай л хэлсэн шүү. Энэ асуудлыг хэрхэн шийдэх гаргалгаа бас тийм амар биш байна. Их амархан биш байна. Тийм учраас бид бас энэ дэд хороогоороо дамжуулаад энэ эрсдэлийг үнэлдэг, хохирлыг барагдуулах ажил юунаас болсон бэ гэдэгтээ бас их анхаарах хэрэгтэй л дээ. Жишээлэх юм бол Саранчулуун гишүүн бол өчигдрийн ажлын хэсгийн хурал дээр бас хэлж л байсан. Мэдрэгч гээд байгаа зүйл маань өөрөө дуу дохио гэрэл анивчдаг. Сонсголгүй хүн унтаж байвал яах вэ. Хараагүй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэндээ энэ чинь яаж хүрэх юм. Яаж мэдэгдэх юм гээд л маш олон асуудлууд бид ярих ёстой юм. Асуудлыг цогцоор нь авч хэлэлцэх л хэрэгтэй.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хэдүүлээ бас жоохон ялгаж, шийдвэртээ оруулах ёстой юм уу, яах ёстой юм. Хотын өөрийнх нь агаарын үзүүлэлтүүд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ гэж бий. Түүнийг нь л хангах ёстой бид. Айл бол хэдийгээр гал түлж гэрээ дулаацуулж бусад хэрэглээгээ хангаж байгаа ч гэлээ гэсэн дотроо утаа гаргадаг зүйл биш шүү дээ. Бүх утаа, угаар юм нь гадагшаа л гарах ёстой. Тэгэхээр зэрэг өнөө галлалт, тэгээд өнөө галлагааны үйл явцад битүүмжийн алдагдалгүй байдал энэ юмтайгаа эргээд үүсэж байгаа юм. Тийм учраас угаартаад нас барчихна гэдэг ойлголт ер нь өөрөө их сонин ойлголт шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Бид айлууддаа дээр үеийн тулгатай байгаа бол ийм юм яриад байж болно. Гэтэл зуухандаа гал түлээд, яндангаараа утаа нь гарч байгаа бол гэртээ угаартаад эндчих асуудал бол бас ойлгоход их төвөгтэй ойлголт. Гагцхүү энд бидний хэнэггүй гэдэг юм уу техникийн нөхцөл нь хангагдаагүй байгаа үйл явцтай л холбоотой зүйл. Үүнийгээ арилгах ёстой. Тэр мэдрэгч энэ тэр бол зүгээр л урьдчилан сэргийлэх тохиолдлын л үйл явц шүү дээ. Гэрт чинь ийм юм үүсэж байна. Аль нэг газраараа заавал юу алдалт өгч байгаа юм байна гэдгийг өгч байгаа л мэдээлэл. Тийм учраас энэ тэр юмнуудаа хэдүүлээ их зөв байдлаар нь тусгаж оруулж, энэ гарсан шийдвэр яах аргагүй хотын өнөөгийн агаарын бохирдлыг бууруулах иргэдийнхээ үүнээс үүдэлтэй сөрөг нөлөөллийг гэдэг юм уу даа иргэдэд үзүүлээд байгаа сөрөг нөлөөллийг бууруулах үйл явц л байх ёстой. Тэгэхээр энэ рүү чиглэсэн бодлогын том шийдэл зохицуулалтыг хийх ёстой болов уу. Энэ тогтоол дотор. Мэдээж нэг том юм тавьчихаад түүнийгээ хараад суугаад байж таарахгүй. Завсрын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд бий. Тэр нь зуухаа ч ярих ёстой, түлшээ ч ярих ёстой, яндангаа ч ярих ёстой, мэдрэгчээ ч ярих ёстой. Тэр агаарын чанарыг сайжруулдаг, шүүдэг, барьдаг тоног төхөөрөмжүүд бас зөндөө бий болчихсон биз дээ. Тэрнээсээ авхуулаад олон зүйлсийг ярьж болно. Тэр чиглэлийн юмнуудыг нь зөв өгөх ёстой болов уу гэсэн ийм л бодолтой байна.

Гишүүдээс олон сайхан саналууд гарч ирж байна. Ажил хэрэг болгомоор. Тэгэхээр би эндээс тогтоолын төсөлд гишүүдээс гарсан саналуудыг тусгаад

ингээд дэмжчих үү гээд санал хураалгачих гээд байна шүү дээ. Аюултай юм болох гээд байна. Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна гэхээр 15 минут түр хуралдаанаа зогсоогоод, Чинбүрэн гишүүнтэйгээ тогтоолын заалт болгон дээр саналтай байгаа гишүүд хоорондоо ярилцаад, томьёоллоо сайжруулчихаад энэ заалт дээр бид ийм томьёоллын сайжруулалт хийсэн гээд танилцуулчихвал амар байна. Тэгэх юм бол бидний яриад байгаа зүйлүүд энэ өрөөн дотор цацагдаад өнгөрөхгүй. Гарах гэж байгаа шийдвэр дотроо яг шигдэж ороод, тэгээд эргээд авч хэрэгжүүлэх арга хэмжээ юмандаа үр нөлөөгөө үзүүлэх юм л гэж ингэж л хараад байна шүү дээ тэгэх үү.

Үгүй ээ үгүй тэгэхээр хий яриад баахан цаг авах гээд байна. Шууд саналтай байгаа гишүүд одоо бол санал гэдэг чинь ерөнхий юм ярихгүй. Тогтоолынхоо заалт болгон дээр ийм санал байна гэдэг юмаа яриад Чинбүрэн гишүүнтэйгээ яриад тогтоолынхоо заалтыг шинэчлээд томьёолоодхооч. Үгүй ээ үгүй тэрний чинь дараа үг хэлүүлбье. Эхлээд хэдүүлээ үүнийг ингэж янзалж авахгүй бол хүн болгон 1, 1 юм яриад, энэ гишүүдийн гаргасан саналыг шийдвэрийн төсөлд шингээгээд дэмжчихье гэдэг л юм ярих гээд байна шүү дээ энэ чинь. Үг хэлж болно.

Тэгвэл санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Уянга гишүүнээр, Жаргалан гишүүнээр тасаллаа. Уянга гишүүн саналаа хэлбье.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ агаарын бохирдолтой холбоотой сонсголд бол ажилласан. Өчигдөр бас бид нар ажлын хэсгийн гишүүд 2 цаг гаруй сууж байгаад яг энэ Засгийн газар луу өгч байгаа чиглэл дээр бол нэлээн ярилцсан учраас одоо энд гарсан байгаа нийт 13 заалт бүхий чиглэлтэй, тэгээд нийт 4 зүйлтэй энэ чиглэл бол Засгийн газар луу бол өгөгдөх гэж байна. Тэгээд үүнтэй холбоотой чиглэлд өөрөө ороод ажиллаад, саналаа албан ёсоор өгчихсөн байгаа учраас чиглэлийг бол дэмжиж байгаа. Тэгэхээр агаарын бохирдолтой холбоотой ер нь энэ сонсголоос өмнө 2019 онд сонсгол явагдаж байсан. Сонсголын тайлантай нэгт нэгэнгүй танилцаж байхад энэ удаагийн сонсголын үр дүнд бид нар Засгийн газар луу чиглэл өгч байгаа шиг ийм ажил бол хийгдээгүй юм билээ.

Тэгэхээр бүгдээрээ энэ чиглэлийг гаргаад, чиглэлийнхээ дагуу хийсэн ажлыг Засгийн газраас намрын чуулганы эхний 7 хоногт төлөвлөгөөг нь, хийсэн ажлыг нь сонсох гэж байгаа нь бол Чинбүрэн ахлагчтай энэ ажлын хэсгийнхний хийсэн энэ чиглэл бол давуу зүйл болж байгаа гэж бол үзэж байгаа. Тэгэхээр бүгдээрээ 2025 оны 10 дугаар сарын эхний 7 хоногт бол нэлээн олон асуудал дээр Засгийн газраас байр суурийг нь, бэлтгэл ажлыг нь бол сонсох гэж байгаа. Энэ дээрээ бол энэ энэ дээр заавал ажиллаад өгөөрэй гээд Засгийн газар луу хандаад, хэдэн зүйлийг бол тодруулж хэлмээр байгаа юм.

Хамгийн эхнийх нь болохоороо Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой холбоотойгоор олон гишүүд бас санал гаргасан. Ерөнхий сайд ахалдаг юм уу, эсвэл аль нэг Шадар сайд ахлах хэрэгтэй гэсэн Батчимэг гишүүний саналтай бол 100 хувь санал нэгдэж байгаа. Яагаад тэгж байгаа юм бэ гэхээр ер нь бол орчны бохирдлын асуудал бол агаарын бохирдол, дотор орчны бохирдол гээд Сангийн яам бол санхүүжилттэй холбоотой, ЭХЯ гэхээр дулаалгатай холбоотой, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам мөн дулаан алдагдалтай холбоотой, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон бусад Боловсролын яам хүртэл энд хамаатай учраас заавал энэ орчны бохирдлыг

бууруулах үндэсний хороог бол салбар хоорондын асуудлыг мэдэж байгаа ахалж байдаг энэ хүн бол ахлах ёстой гэж ийм саналтай байгаа.

Хоёрдугаарх нь болохоор Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр яг энэ чиглэлийг унших юм бол 2025 онд дуусах гэж байгаа юм байна гээд бол харна. Тэгэхээр энэ Засгийн газраас намрын чуулганы эхний 7 хоногт орж ирж бид нарт явцаа танилцуулахдаа Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн дараагийн төслийг нь ч юм уу, эсвэл баталчихсан байхаар ч юм уу танилцуулаасай гэж хүсэж байна.

Мөн чиглэлд дотоод орчны бохирдлын асуудал туссаныг бол дэмжиж хүлээж авч байгаа. Тэгэхээр ер нь өвлийн улиралд ялангуяа сургууль, цэцэрлэгийн дотор орчны ариун цэврийг бол бид нар анхаарах ёстой. Тэгэхээр энэ дээр бас ямар ажлуудыг хийсэн, хийх гэж байгаа талаараа Засгийн газраас мэдээллийг нь авах хэрэгтэй. Ингэж бодож байна.

2019 оны тайланд ч бас туссан байсан юм. Ер нь бас Батжаргал гишүүн ч түрүүн хэллээ. Технологи бол маш их хөгжчихсөн. Бид нар бас энэ ажлын хэсгийн хүрээнд дэд хэлэлцүүлгийг Түлш, технологи гэдэг хэсэг дээр бүтэн 1 өдөр бол ярилцсан. Тэгэхээр энэ дээр юу болсон бэ гэхээр цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй халаагуурууд ямар сайн хөгжсөн байгааг бол олж харсан. Гэр, байшин дулаалах арга хэрэгслүүд бас дэвшсэн байна лээ. Тэгэхээр энэ бүх мэдээлэл ажлын хэсэг дээр цугласан байгаа. Энийг бас Засгийн газраас аваад, манай энэ чиглэлийн 7-д туссан байгаа иргэдийг мэдээллээр хангах ажлаа тултал нь сайн хийгээд өгөөч ээ. Энийг бас эргээд бид нар 10 дугаар сарын эхний 7 хоногт уулзалдахдаа Үндэсний хорооноос тайлан хэлбэрээр, төлөвлөгөө хэлбэрээр бас авах саналтай байна. Тэгээд бас энэ чиглэлтэй холбоотойгоор энэ чиглэлд туссан байгаа нэг зүйлийг заавал тодруулж хэлэхийг хүссэн нь яг энэ утааны сонсголын үеэр бол Брид Монголиа гэх мэт ийм төрийн бус байгууллагуудтай бол утааны чиглэлээр бол нэлээн тийм мэдээллийг нь сонсож хамтарч ажилласан. Хамгийн ойрын тулгамдаж байгаа асуудал нь бол төрийн байгууллагад байгаа мэдээллийг бид нарт өгдөггүй, нээлттэй судлаачдад өгдөггүй гэсэн ийм асуудал байсан. Энийг бид нар төвөггүй шийдчих байх. Тэгээд энэ дээр бас Засгийн газрыг хамтарч хувийн хэвшлээ .../минут дуусав/

Ж.Батжаргал: Баярлалаа. Ундраа гишүүн.

А.Ундраа: Энэ тогтоолыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхээр Засгийн газрын зүгээс бас тодорхой арга, алхмууд хийгдэж байгаа энэ асуудал нь бас давхардах магадлалтай юм байна. Гэхдээ яах вэ ямар ч гэсэн бид энэ ажлын хэсэг байгуулагдаад ажилласны хувьд Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол заавал гарах ёстой гэж бодож байна. Давхардсан байлаа ч гэсэн энэ асуудал их чухал учраас 1 санал бол сая Жаргалан гишүүн боловсруулж, бид нарт тараасан байгаа агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Утааны асуудлаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай гээд энэ тогтоолын төсөл боловсруулсан байна. Энэ дээр бас давхцаагүй, шинэ, зөв зүйтэй санаанууд туссан байгаа учраас энэ 2 төслийг нэгтгэх нь зүйтэй гэж бодож байна.

2 дугаар санал бол “Тавантолгой түлш” гэж нэртэй компани байгуулагдаад ингээд түлш үйлдвэрлэж байгаа энэ явц заавал Тавантолгойгоос нүүрсээ авах, эсвэл Багануурын нүүрсийг ашиглан түлш үйлдвэрлэх талаар ажлын хэсэг дээр

хэд хэдэн санал гарсан. Энэ Тавантолгой гэдэг нэрийг заавал энд тусгахгүйгээр, Улаанбаатар түлш гэж нэрийг солих чиглэл хүргүүлэх саналтай байна. Өөрөөр хэлбэл энэ түлшний асуудал бол ихэнхдээ зөвхөн Улаанбаатар хотод хэрэглэгдэж байгаа түлш учраас эх үүсвэр нь хаанаас байна вэ гэдгээсээ үл хамаарна.

3 дугаар санал бол энэ дулааны асуудал дээр гарсан саналууд дээр нэмэх нь нөгөө аль болох гал түлэхийг багасгавал аяндаа утаа өөрөө багасна. Тэгэхээр эх үүсвэр талдаа нөгөө гал түлж л байгаа цагт утаа гарч л таарна. Тийм учраас энэ тогтоолын төсөл дотроо дулаалгын нэгдсэн стандарт боловсруулах энэ дээр 10 дугаар заалт дээр нэмэх нь манай Монгол Улсын барилга байгууламжийн дулааны норм норматив стандарт хөгжсөөр байгаа. Гэхдээ тэр заалт дотор дулааны хэмнэлттэй барилга байгууламж, пассив барилга байгууламж гэдэг заалт нь дулааны хэмнэлтгүйгээр баригдсан байгаа байшин нь барилгын норм дүрмийг хангасан гэж тооцогдохгүй байхуйцаар чангалах хэрэгтэй байгаа юм.

Өөрөөр хэлбэл бол энэ дулааны норм дүрэм сул явж ирсний нэг гор нь энэ утаа ийм их байгаа үндэс шалтгаан нь болоод байгаа. Тэгэхээр энэ норм дүрмийг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэдгийг Засгийн газарт хүргэж байгаа чиглэлдээ тусгаж өгнө үү гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Ганбаатар гишүүн санал хэлье.

Г.Ганбаатар: Яах вэ, өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан л даа. Ерөнхийдөө сонсголын дараах дүгнэлт, дээрээс нь Засгийн газарт өгөх чиглэлийн тогтоолын төсөл орж ирсэн. Сая Ундраа гишүүнтэй хэд хэдэн санал маань давхардчихлаа.

Нөгөө тал дээрээ энэ Жаргалан гишүүний өргөж байгаа энэ тогтоолын төслөө хэдүүлээ нэгтгээд аятайхан чиглэл Засгийн газар луу өгчихье. Тэр нь тэр нь их зөв зүйтэй саналууд гарсан байна. Тэгээд энэ дээр ер нь 3 гол зүйл байгаа шүү дээ. Утаанд ахиж хэдүүлээ ер нь нэг мөнгө зарахаа больё. Энэ утаа гэдэг чинь далимдуулаад айхтар том бизнес болчихлоо гэдэг асуудал байгаа.

2 дугаарт эрчим хүчний болон дулааны халаалтын ямар технологиуд байгаа юм. Тэр технологиудыг нэвтрүүлээд иргэд түүнийгээ өөрсдөө сонголтоороо ашиглах боломжийг нь төр санал болгох хэрэгтэй гэж бодож байгаа. Ерөнхий саналуудаа хэлэхэд.

Дээрээс нь байгаа жоохон нөөцөө яндан утаанаасаа салж байгаа хүмүүстээ нэг урамшуулал олгодог систем рүү орчихвол энэ ер нь яваандаа гайгүй болчих байх. Тэр тогтоолын төсөл дээр би өчигдөр ажлын хэсэг дээр байр сууриа илэрхийлсэн. Тэр хатуу түлшийг нийслэл болоод орон нутаг, суурин газарт гэдэг дээр нийслэл дээр бол ойлгож байгаа. Суурин га р гэдэг чинь аймгийн төв, сумдын төвүүд орно. Энэ болохгүй. Ерөөсөө ноолуур шиг юм болно шүү. Ний нуугүй хэлэхэд амьдралаас хол хөндий. Суурин газар гэдэг чинь аймгийн төвийн оршин суугчид, гэр өрхүүд, сумын төвийн, тэгээд сүүлд нь хориглодог аймаг төв дээр баахан далимдуулсан шахмал түлшний үйлдвэрүүд нэртэй юм болгоод, тэгээд баахан бизнес болчих вий гэсэн болгоомжлол байгаагаа дахиад хэлье.

Яг үндсэндээ бол манай төрөөс ингээд явуулж байгаа гаргаж байгаа бодлого нь зарим талаараа бас арай дэндүү амьдралаас хөндий юмнууд гараад байдаг. Саяын нөгөө ноолуур шиг юм болох вий гэсэн болгоомжлол байгаа. Нэгийг нь

дэмжих гэж байгаа нэрийн доор нөгөөдөх нь унагачих вий гэдэг ийм болгоомжлол байгаа гэдгээ хэлье.

Ж.Батжаргал: Баярлалаа. Найдалаа гишүүн санал хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэлэх боломж олгосонд баярлалаа. Би бас энэ ажлын хэсэгт орж ажилласан. Ямар ч байсан ажлын хэсэг маань ялангуяа Чинбүрэн гишүүн ахлаад ажилласан маш үр дүнтэй сайн ажилласан гэж бодож байгаа. Маш шахуу хугацаанд. Тэгээд зүгээр тогтоолын төсөлтэй танилцсан. Сая гишүүдийн үгийг сонсож байхад, дахиад үзэж байхад бид нарт хэдэн тодотгомоор зүйл байгаа юм байна. Тэгээд тэрийгээ хэлчихье гэж бодсон юм.

1 дүгээрт энэ асуудлуудаа эрэмбэлмээр санагдлаа. Яагаад гэвэл зарим ийм техникийн чанартай, жижигхэн зааврын чанартай юм болон бодлогын чанартай юм холилдчихсон байна. Жишээлбэл 8 дугаар зүйл дээр байгаа тэр бодлого, хөтөлбөр шинэчлэх гэж байгаа бол 8-д баймааргүй юм 1-д тавьж, анхааралд оруулмаар санагдаж байна. Яг хугацаатай хэзээ газ болох гээд байгаа юм. Хэзээ хатуу түлшээ болих юм, болихгүй юм уу. Ер нь яг иймэрхүү ийм бодлогын чанартай ийм хугацаатай нь тодорхой тавиад явмаар байна. Энийгээ 1-д тавивал яасан юм бэ. Ер нь зүгээр асуудлуудаа эрэмбэлчихвэл яасан юм бэ гэсэн санаа байна. Одоо хэдүүлээ ёстой жинхэнэ түрүүн Батжаргал даргын хэлдгээр 15 минут суух гэж байхдаа эрэмбэлчихмээр байна.

2-т нь хариуцах эзэн олон гишүүн хэллээ. Яг сонсголын үеэр ч зөндөө ярьсан. Ер нь 10 жилийн өмнө утааг хэн хариуцаж байсан юм гэвэл одоо бид нар санахгүй байгаа биз. Одоо ч гэсэн дээ хайгаад үзэх юм бол эзэн нь олдохгүй. Байгаль орчны сайд гэж байгаа боловч, хороо гэж байгаа боловч тэгээд яг ингээд явсаар байгаад замраад нийслэл ч юм шиг, хороо ч юм шиг, Ерөнхий сайд ч юм шиг болчихдог. Хуулиараа Засгийн газар хариуцна гэж байгаа боловч энэ тогтоолын төсөлд яг хариуцах эзнийг нь тодорхой болгоё гэдгийг тодорхой зааж өгвөл яасан юм бэ. Тэгээд яг намрын чуулганаар асууя хэдүүлээ. Яг хэн хариуцах юм. Аль сайд нь гээд. Тэгээд би гишүүдтэй санал нэг байна. Ерөнхий сайд юм уу эсвэл аль нэг Шадар сайд яг ингээд хар толгойгоороо хариуцаад авмаар байгаа байхгүй юу. Энийг жишиг болгохгүй бол өнгөрсөн 20, 30 жил дандаа эзэнгүй явсан байна лээ. Эзэнтэй ч юм шиг, эзэнгүй ч юм шиг.

3-д нь “Тавантолгой түлш” компани гээд маш чухал нэг компани байгаа. Энэ компанийн тухай бид нар орхигдуулчихсан юм шиг санагдлаа. Тэгээд “Тавантолгой түлш” компанийн менежмент бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн зохион байгуулах, үр ашигтай болгох гэдэг зүйлийг оруулахаас өөр аргагүй. Оруулмаар байна. Тэгээд энийг Засгийн газраас яг тайланг нь асуумаар байгаа юм. Хэрвээ “Тавантолгой түлш” компани ямар нэгэн авлига, хулгайгүй маш сайн ажиллаж байгаа, болж байгаа гэж байгаа тэрийгээ намрын чуулганаар нотлог. Үгүй бол яаж шинэчилснээ бид нар тайлагнамаар байгаа байхгүй юу. Их Хуралд, иргэдэд. Тэгээд энийг оруулж өгье гэсэн санал байна.

4-д нь зүгээр яах вэ гишүүд ярьсан болохоор энэ тогтоолын төсөлд байгаа нөхөн олговортой холбоотой асуудал. Энийг эргэлзэхгүйгээр нөхөн олговрыг заавал олгодог байхаар хууль, эрх зүйн орчныг тогтоох нь тогтоолын төсөлд орсон байгаагаараа зөв гэж бодож байна. Хүн амины хэрэг гарлаа гэхэд заавал буруутай этгээд нь тогтоогддог, хариуцлагаа үүрдэг. Яг тэрэнтэй адилхан гэртээ унтаж

байгаад нас барна гэж байгаа байж болшгүй зүйл. Тэгээд энд заавал нэг буруутай зүйл байх ёстой. Стандарт нь буруу байна уу, түнш нь буруу байна уу, эсвэл иргэн өөрөө хариуцлага алдсан байна уу. Ямар нэгэн байдлаар хэн нэгэн буруутай байх ёстой. Буруутай байгаа бол тэр албан тушаалтан хариуцлага алдсан байна уу. Нөхөн олговрыг тодорхой тогтоогоод, олгодог соёлыг тогтоох юм бол хариуцаж байгаа даргаасаа авхуулаад иргэн хүртлээ бүх талдаа хариуцлага нь тодорхой болох юм. Тэгж байж нөхөн олговор олгодог болж байж хариуцлага тооцдог байж байж дараа нь угаарыг багасгах, хүн нас бардаггүй болох, аюулгүй байдлыг хангах гэдэг нь хөшүүрэг нь болох юм байна. Яг л замаа засахгүй байж байгаад, машин эвдрэх юм бол тэрийг нь зам засах ёстой газраас нь эсвэл хотын захиргаанаас нь нэхдэг болох яг тэрэнтэй адилхан зүйл байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ зарчмыг хэдүүлээ яг энэ тогтоолын төсөл оруулсан нь маш зөв байна. Энийг яг тууштай эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажиллах юм шүү. Ийм саналтай байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Жаргалан гишүүн саналаа хэлье.

Б.Жаргалан: Миний хувьд тус Байнгын хороонд харьяалагддаггүй байгаа. Тэгээд өнөөдөр Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төсөл хэлэлцэж байгаатай холбогдуулаад бас өмнө нь өөрийнхөө бас ажиллаж байсан юм тогтоолын төслийг нэгтгэх зорилгоор аваад ирчихсэн байж байгаа. Тэгээд энд нэмж оруулах саналуудаа товч танилцуулъя.

1 дүгээрт Засгийн газарт Агаарын тухай хуулийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хуралд 2025 оны 5 дугаар сарын 15-ны дотор тайлагнах.

2-т түрүүний ярьсан бид итгэл үнэмшлээ нэг мөр болгоё гэдэг тэр сургамжийн хүрээнд 3 жилийн дотор нийслэл болон төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх буюу 3 жилийн дотор утаагүй болгох зорилтыг дэвшүүлэх. Энэ бол г улс төрийн манлайлал үзүүлж байгаа ийм заалт гэж ойлгож байгаа.

3-д төр дахиж утаанд мөнгө зарахгүй байх гэсэн тэр сургамжийн хүрээнд.

Агаар бохирдуулж буй аливаа этгээд арга хэмжээнд төрөөс татаас урамшуулал олгохгүй байх. Төсвийн хөрөнгөөр зуух, яндан, түлш зэрэг агаарын бохирдлын эх үүсвэрийг санхүүжүүлэхгүй байх. Энэ хүрээнд технологийн горим алдсан “Тавантолгой түлш” ХХК-г татан буулгаж, чанар стандартын шаардлага хангасан утаагүй шахмал болон хийн түлшний үйлдвэрлэл, худалдааг хувийн хэвшлийн санал санаачилгад тулгуурлан зах зээлийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах.

4-д гэр, байшингаа дулаалсан эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, нарны цахилгаан үүсгүүр зэрэг байгальд ээлтэй утаагүй технологийн шийдэл сонгон яндангаа буулгасан гэр хорооллын өрхөд олгох урамшууллын болон ногоон зээлийн тогтолцоог хувийн хэвшил иргэний нийгмийн оролцоотой бүрдүүлэх. Үүнд бол 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 30 хүртэлх саяын ногоон зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ гэсэн заалт орсон байж байгаа. Тэгээд үүнтэй бас уялдуулаад нэг ийм тогтолцоо бүрдүүлчихье гэсэн санаа.

5-д хашаандаа 5-аас доошгүй мод тарьж ургуулсан айл өрхийг цахим бүртгэлд хамруулж, урамшуулах.

6-д бага чадлын тархмал эх үүсвэрийг угсрах суурилуулахад шаардлагатай тусгай зөвшөөрөл шаардлагуудыг эрс хөнгөвчлөх буюу эрчим хүчний эх үүсвэр талдаа тухайлах юм бол сэргээгдэх эрчим хүчинд суурилсан эх үүсвэр бүрдүүлэх ийм бага чадлын тархмал эх үүсвэрүүдийн зөвшөөрлийн тогтолцоог бол эрс хөнгөвчлөх ийм байдлаар шийднэ гэсэн санаа.

Тэгэхээр цаашдаа болохоор хүмүүс нөгөө эх үүсвэр талдаа маш санаа зовоод байгаа юм л даа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд судлаад үзэхэд Улаанбаатарын гэр хорооллын айл өрхүүдэд 200 мянга орчим айл өрх байгаа. Тэдгээрийн ерөнхийдөө жилдээ цахилгаан халаагуураар халаах нөгөө чадлын хэмжээ нь 600мвт байгаа байхгүй юу. Тэгэхээр бол харьцангуй гайгүй. Жишээлэх юм бол ЭХЯ-аас манай улсын 1800мвт хүчин чадлыг 3 жилийн дотор 3500мвт хүргэнэ гээд байгаа шүү дээ. Тэгэхээр бол Бөөрөлжүүтийн 300мвт удахгүй орно гэж байгаа. Баян дээр 660мвт орно гэж байгаа. Тавантолгойн станц бас орно гэж байгаа. Гэх мэтчилэн зөвхөн цахилгаан эрчим хүчээр халаах яг тэр боломж чинь бол ойрын 2,3 жилдээ бүрдчихнэ гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр давхар давхар шахаад явах боломжтой. Мэдээж хэрэг зөвхөн цахилгаан эрчим хүчээр биш, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээр ч гэдэг юм уу ингээд маш олон технологийн сонголттойгоор бид нар энэ боломжийг, энэ шийдлийг бий болгох боломжтой гэдэг дээрээ санал нэгдчихмээр байгаа юм. Мэдээж хэрэг бас нөгөө түгээх дамжуулах сүлжээндээ бас бага зэрэг хөрөнгө оруулалтууд бол оруулах ёстой. Тэгэхээр нөгөө зууханд зараад байгаа мөнгөө “Тавантолгой түлш”-д жишээлбэл жил болгон 400 тэрбум төгрөг зарж байгаа тэр мөнгөө бол нөгөө дэд бүтэц рүүгээ заръя гэх мэтчилэн богино хугацаанд ийм ухаалаг зарцуулалтууд хийгээд, тэгээд 3 жилийн дотор л ерөөсөө утаагүй больё гэсэн зорилт тавья гэсэн санаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Гишүүд санал хэлж дууслаа. Гишүүдээс гарсан энэ олон саналууд бас Их Хурлын гишүүн энэ асуудалтай холбогдуулж тогтоолын төсөл боловсруулж орж ирж байгаа. Тэгээд эд нарын уялдааг хангах үүднээс түрүүний ярьж байдгаар ажлын хэсгийн ахлагч, гишүүдтэйгээ уулзаад тухайлсан тухайлсан заалтууд дээр нь найруулгынхаа шинэчлэлийг хийгээд, түүнийгээ танилцуулаад дэмжүүлчихсэн нь дээр хэдүүлээ.

Тийм учраас энэ асуудлыг тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг түр хойшлуулчихъя. Тэгээд дараагийн 2 асуудлыг хэлэлцээд, тэрнийхээ дараа тогтоолын төсөлд орсон өөрчлөлтөө сонсоод, тэгээд хэдүүлээ дэмжээд явъя гэсэн ийм юутай байна.

13.01 цаг.

3 дахь асуудалдаа оръё.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулж ирье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хаа байна. Ажлын хэсэг Ц.Уранчимэг Байгаль орчин,

уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Батмөнх Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх, Эрдэнэбилэг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын зөвлөх гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд орж ирлээ.

Энэ асуудлыг эртээд хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж явах явцад Байнгын хороо болон холбогдох гишүүдээс гарсан юм бол эрх зүйн дүгнэлт гаргуулах уу гэдэг асуудал байгаад байсан юм. Тэгэхээр одоо би юу гэх гэж байна гэхээр анхны хэлэлцүүлэг учраас зүйл заалт бүрээрээ хэлэлцэх ёстой. Манай Их Хурлын Байнгын хорооны ажлын алба бол энэ томьёолол бүх юмаа бэлдээд оруулаад ирчихсэн байна.

Нөгөө талд нь тэр эрх зүйн дүгнэлт гаргуулах уу, шууд явчих уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгээд гишүүдийнхээ ерөнхий бас нэг байр суурийг сонсчихоод аль шийдэл дээрээ тогтоно, түүгээрээ явчихъя гэсэн бодолтой байна. Саналтай гишүүд байна уу. Яамаар байна. Шууд анхны хэлэлцүүлгээ явуулчихъя гэсэн санал байна шүү дээ. Тэгвэл ингэж тогтлоо .

Дэгийн тухай хуулиараа зүйл заалт бүрээр нь хэлэлцэх ёстой.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу. Наранбаатар гишүүн. Наранбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад дараах зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа юм. Томьёоллыг уншиж танилцуулъя.

1 дүгээр зүйл буюу 25.7 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах санал байна.

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” Гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал оруулж байна.

Ж.Батжаргал: Одоо санал хураагаад явчихна биз дээ. Энэ саналтай холбогдуулж уу. Лүндэг гишүүн саналтай холбогдуулж үг хэлье.

С.Лүндэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ “агнах” гэдэг үгээ бид нар Монгол хэлнийхээ үндсийг сайн бодохгүй бол “агнах” гэдэг чинь “ан агнах” гэсэн үг шүү дээ. Тэгэхээр бас бид нар энэ хуулийн зүйл заалт дээр яг зөв үгээ оруулахгүй бол дараа нь энийг буруугаар ашиглах зүйл гарах вий дээ гэсэн ийм санаа зоволт байна. Тийм учраас энэ дээрээ манайхан сайн анхаараарай.

Ж.Батжаргал: Эрх зүйн хэллэг соёлын тухай л ойлголт юм. Бид хэд төлөвлөгөөтэй юмаа агнах тухай ярьцгаагаад байдаг. Зайлшгүй шаардлагын нөхцөлд бол алах тухай ярих гээд байгаа юм шиг байгаа юм. Тэгээд хэлэхээр энэ эрх зүйн баримт бичиг талдаа өнөө хэллэг, соёл нь яаж буугаад байгаа юм. Би ч бас л нарийн л ойлгохгүй л байгаад байгаа. Амгаланбаатар гишүүн.

О.Амгаланбаатар: Энэ дээр бас юу яасан юм. Нөгөө хэлэлцэх эсэх дээр яриад ер нь бол алах гэж оруулах ёстой юм байна лээ. Гэтэл энэ чинь бас яг саяын Батжаргал хуралдаан даргалагчийн хэлдгээр бас нэг болохгүй байна. Тийм учраас агнахаар нь оруулъя гэдэг ийм асуудал яригдсан л даа. Түүнээс уг нь агнах гэдэг чинь зохион байгуулалттай үйл ажиллагаа шүү дээ. Гэхдээ ингэж оруулахаас л өөр аргагүй л юм байна лээ л дээ.

Ж.Батжаргал: Байгаль орчин, уур амьсгалын яамны Уранчимэг нэг тодорхой тайлбар мэдээлэл өгөөч. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ц.Уранчимэг: Яг нөгөө амьтны тухай хуулиараа одоо байгаа байдал бол яг агнах гэдгээр л явж байгаа. Тэгээд алах гэхээр бол яагаад ч тийм хэллэг хэрэглэж болохгүй. Энэ нь өөрөө яг амьтны эрхийн асуудал яригдана. Бас олон улсын биологийн олон янз байдлын конвенцын асуудал дээр бас энэ зүйл хөндөгдсөн байгаа. Тэгэхээр энийг нийт утгаар нь тэр нөгөө хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал гээд одоо байгаа 35.1-д байгаа заалтыг л өөрчлөн найруулах ер нь бол яамнаас саналтай байгаа.

Ж.Батжаргал: Наранбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Саяын санал хураалттай холбогдуулж Сэддорж гишүүн горимын санал гаргах гээд байна уу.

Р.Сэддорж: Энэ төхөөрөмж ажиллахгүй байна. Хурууны хээ ажиллахгүй байна. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Ж.Батжаргал: Сэддорж гишүүний гаргаж байгаа горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгах асуудал яригдаж байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Горимын санал дэмжигдсэн тул түрүүчийн Наранбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг 68 хувиар дэмжсэн байсан. Тийм учраас Наранбаатар гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор хурааж байна. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнгүй. Техникийн саатал үүссэн гээд хэд хэдэн гишүүд горимын санал гаргая гэж байна. Батчимэг гишүүн санал гаргая.

П.Батчимэг: Дэмжсэн боловч төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хурааж өгнө үү.

Ж.Батжаргал: Батчимэг гишүүн саяын санал хураалтыг дэмжиж санал өгсөн боловч техникийн шалтгаанаас хамаараад санал өгөлт хангагдсангүй. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Батчимэг гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Хуралдаанд оролцсон гишүүдийн 62,5 хувиар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн тул Наранбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Хуралдаанд оролцсон гишүүдийн 68,8 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Батчимэг гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглэгдэж байна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулах асуудлууд дуусаж 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Одоо хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу. Наранбаатар гишүү.

Н.Наранбаатар: Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргаж байна.

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал оруулж байна.

Ж.Батжаргал: Наранбаатар гишүүний гаргаж байгаа саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулж байна. Хуралдаанд оролцсон гишүүдийн 68,8 хувийн саналаар дэмжигдлээ. Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулна. 3 дахь асуудлаа хэлэлцэж дууслаа.

13.13 цаг.

Хэлэлцэх асуудал 4. **“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт үр дүнтэй танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 7 дугаар тогтоолоор байгуулан ажиллуулж байгаа. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд Байнгын хорооны тогтоолоор батлахаар заасны дагуу өнөөдрийн хуралдаанд танилцуулж байна.

Тогтоолын төсөл, удирдамжийн төслийг та бүхэнд хүргүүлсэн. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу. Байхгүй байна. Лүндэг гишүүнээр тасаллаа. Лүндэг гишүүн.

С.Лүндэг: Энэ ажлын хэсэгт би бас орж ажиллах саналтай байна. Миний нэрийг оруулж өгнө үү.

Ж.Батжаргал: Энэ бол ажлын хэсэг нь өмнө нь байгуулагдчихсан. Одоо ажиллах удирдамжийг нь баталж өгч байгаа зүйл байгаа юм.

Тийм учраас орохоор бол та албан ёсоор хүсэлтээ гаргаж, дараагийн хуралдаан дээр бүрэлдэхүүнд нь ороорой. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 56,3 хувиар тогтоолын төслийг дэмжиж, баталлаа. 4 дүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа.

13.16 цаг.

Түрүүний хойшлуулсан өнөө хяналтын ерөнхий сонсгол явуулсантай холбогдуулж “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл дээр сайжруулалт хийж танилцуулах ёстой. Тэгээд санал хураалгах ёстой. Тэр асуудалдаа оръё. Чинбүрэн гишүүнийг дуудаад тогтоолын төслийн аль заалт дээр ямар өөрчлөлт орсон гэдэг томьёоллын сонсьё хэдүүлээ. Хараахан дуусаагүй байгаа юм байна. 15 минут түр завсарлаадахъя.

ЗАВСАРЛАГА.

Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлье. Байнгын хорооны гишүүд хуралдааныхаа танхимд орж ирээрэй. Хяналтын ерөнхий сонсгол явуулж санал, дүгнэлт, түүн дээр тулгуурласан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг ажлын хэсэг бэлтгэсэн. Энэхүү тогтоолын төсөл дээр Байнгын хорооны гишүүд, холбогдох гишүүд зэрэгцүүлж, тодорхой шийдвэрийн төсөл заалтуудыг Байнгын хороонд оруулж ирсэн. Энэ бүгдийг хооронд нь уялдуулан нэгтгэж сайжруулах зорилгоор сая бид түр завсарлаад ажлын хэсэг, холбогдох гишүүд шийдвэрийн төсөл дээрээ ажилласан. Энэ ажилласан талаар ажлын хэсгийн ахлагч Чинбүрэн гишүүн товчхон мэдээлэл өгчихье.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны гишүүдийн саналыг бид бас хүлээж аваад редакцын засвар хийлээ.

Нэгд бас эрэмбэлэх дарааллаар нь оруулах гэдгээрээ бас энэ хөтөлбөртэй холбоотой асуудлыг 8-д байсан заалтаа 1 рүү татаад тавьчихлаа. Жаргалан гишүүний боловсруулсан саналуудаас ер нь бид ойрын хугацаанд стандартдаа хүрье гэдэг том заалтыг бол шууд тэр чигээр нь аваад орчихлоо. 2 дээр оруулчихлаа. Нөгөө ард иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах зорилгоор ер нь мэдрэгчийн ажиллагааг хангах, дээр нь Нийслэл өөрөө их анхаарч ажиллах ёстой. Эрүүл мэндийн байгууллагууд энэ дээр анхаарах ёстой гэдгээ хэвээр нь үлдээгээд, мэдээллийг бас хангах энэ олон нийтийн радио телевизийн цаг агаарын мэдээний хамт ингээд оруулдаг юм үлдсэн. Бид нарын ер нь бол энэ сонсголтой холбоотой гол асуудал бол энэ угаартсан иргэдийн нөхөн төлбөр, хохирлыг барагдуулах гэдгээс сэдэв маш их хүчтэй хөндөгдсөн учраас ерөөсөө энэ эрх зүйн орчинтой больё гэдэг талаасаа энэ зүйл заалтаа үлдээсэн шүү. Энэ байж байгаа.

Мэдээж гэр байрын дулаалгын асуудал бол энд заавал яригдаж байгаа. Энэ хэвээрээ үлдсэн. Хүний эрүүл мэнд хамгаалах зорилгоор гадаад дотоод орчны агаарын юуг нь зөв гэдгийг бас гишүүд нэмж хэлсэн.

Бас нэг зүйл нь Жаргалан гишүүний нөгөө юу 11 дээр орчихсон. Агаар бохирдуулж байгаа аливаа арга хэмжээ, төсөл хөтөлбөр гээд 11 дээр оруулчихлаа. Яг нөгөө компанийг татан буулгах гэдэг нь Засгийн газрын өөрийнх нь асуудал байх. Тэгэхээр бид тэрийг нь оруулахгүйгээр энэ санаанууд их чухал

санаанууд байна. Тэгээд энэ зүйлийг 11 дээр ингээд оруулчихсан шүү. Та бүхэнд хэвлээд өгчихлөө. Харин тэр бас их чухал санаа байна. Энийг харин чуулган дээр хэдүүлээ яриад үүрэг өгчихвөл яасан юм. Бичгээр бишээр. Ер нь нэр өөрчлөх ёстой тэр бас их зөв юм байна лээ шүү. Тэртээ тэргүй Тавантолгой түлшээс авахаа болчхож байгаа гэхээр чинь тийм ээ. Тэрийгээ чуулган дээр яриад явчих уу. Энэ дээр оруулахгүйгээр.

Дээрээс нь гишүүдийн хэлсэн чухал санаа. Нөгөө Ерөнхий сайд Агаар орчны үндэсний хороог ахална гэдгийг бүр яг заалт оруулчихсан Замира гишүүн ээ, энэ дээр ингээд орчихсон шүү. Эзэнжүүлж. Хурал даргалагчаа ингээд болчихлоо.

Ж.Батжаргал: Мэдээлэл сонслоо. Шийдвэрийн төслийг гишүүдийн гаргасан саналуудтай уялдуулж, сайжруулсан тухай мэдээллээ авлаа. Та бүгдэд шийдвэрийн төсөл бас хүргэгдсэн. Үүнтэй холбогдуулж одоо бол асуулт, санал гэхээсээ илүүтэйгээр нэгтгээд тов тодорхой саналтай хүн байна уу. Байхгүй юу. Байхгүй байна. Тэгвэл чуулганы чуулганы нэгдсэн хуралдаанаар уг тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Техникийн тодорхой саатлын улмаас нэлээд олон гишүүд санал өгч чадсангүй. Мандхай гишүүн горимын санал гаргая.

М.Мандхай: Нөгөө техник нь ажиллахгүй байгаад байсан учраас саяын саналыг цуцлаад, тэгээд дахин санал хураалт хурааж өгөөч гэж хүсье.

Ж.Батжаргал: Мандхай гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 62,5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулж, Улсын Их Хурлын чуулганаар тогтоолын төслийг хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мандхай танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөж байна. Хуралдаанд оролцсон гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа.

13.50 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ